



**АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ
КОМПАНИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ТУШААЛ**

2025 оны 12 сарын 22 өдөр

Дугаар A/154


Улаанбаатар хот

**Хүний нөөцийн бодлогын баримт бичиг
батлах тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10, Компанийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.9.10 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Амгалан дулааны станц ТӨХК-ийн “Хүний нөөцийн бодлогын баримт бичиг”-ийг хавсралтаар баталсугай.
2. Энэхүү тушаал батлагдан гарсантай холбогдуулан Гүйцэтгэх захирлын 2021 оны А/111 дүгээр тушаалыг хүчингүйд тооцсугай.
3. “Хүний нөөцийн бодлогын баримт бичиг”-ийг үе шатны дагуу зохион байгуулж, хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтэс (Т.Ичинхорлоо)-т даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  М.МӨНХӨӨ



АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-ИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА:

Монгол Улсын Засгийн Газрын 2013 оны 35, 55 дугаар тогтоолоор Улаанбаатар хотын гэр хорооллыг орон сууцжуулах, хотын зүүн бүсийн байгууллага, иргэдийг чанартай дулааны эрчим хүчээр хангах зорилгоор 348 МВт-ын хүчин чадалтай Амгалан дулааны станцыг барьж байгуулахаар шийдвэрлэсэн. Энэхүү шийдвэрийн дагуу Монгол Улсын Засгийн Газрыг төлөөлж Эрчим Хүчний Яам, Эдийн Засгийн Хөгжлийн Яам хамтран БНХАУ-ын “Чайна Машинери Инженеринг Корпораци” /СМЕС/-тай Баянзүрх дүүргийн 8 дугаар хорооны нутаг дэвсгэрт Амгалан дулааны станцыг түлхүүр гардуулах нөхцөлтэйгээр барьж байгуулах концессын гэрээг 2013 оны 4 дүгээр сард байгуулснаар барилга угсралтын ажил 2013 оны 8 дугаар сарын 21-ний өдөр эхэлсэн.

Улсын комиссын шийдвэрээр 2015 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн 15 цагт зуухны туршилт, тохируулгын анхны галлагааг эхлүүлж, дулааны эрчим хүч түгээж эхэлсэн. Мөн станцын нээлтийн үйл ажиллагаа 2015 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр зохион байгуулагдсан.

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 106 дугаар тогтоолоор баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх хөгжлийн төслийн жагсаалтад Амгалан дулааны станцыг 116 МВт-ын хүчин чадалтай нэг зуухаар өргөтгөхөөр баталсан. Энэхүү шийдвэрийн дагуу Монгол Улсын Засгийн Газрыг төлөөлж Эрчим Хүчний Яам, БНХАУ-ын “Хунан индустриал экүйпмент инсталэйшн” компанитай Амгалан дулааны станцыг QXF 116-1.6/130/70-L маркийн 116 МВт-ийн нэг зуухаар өргөтгөх төслийг хэрэгжүүлэх ажлын гэрээ байгуулсан. Энэхүү төслийн бүтээн байгуулалтын ажил 2022 оны 06-р сарын 07-ны өдөр эхэлсэн. Өргөтгөлөөр баригдсан зуух, үндсэн болон туслах тоноглолууд 2024 оны 09 дүгээр сарын 15-ны өдрөөс дулааны эрчим хүч үйлдвэрлэх ажиллагаанд оролцсон.

Амгалан дулааны станцад 2015 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр Улсын бүртгэлийн Ерөнхий газраас 0000110810 дугаартай улсын бүртгэлийн гэрчилгээ олгогдоноор бие даасан үйл ажиллагаа явуулах эрх бүхий хуулийн этгээд болсон.

Монгол Улсын Эрчим хүчний яамны 2016 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 1691/16 тоот “Ажил үйлчилгээ эрхлэх” тусгай зөвшөөрөл, Эрчим хүчний зохицуулах хорооны 2021 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн №10/2016 тоот “Дулаан үйлдвэрлэх” тусгай зөвшөөрөл тус тус олгогдсон.

1.2 АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦЫН СУУРИЛАГДСАН ХҮЧИН ЧАДАЛ:

Суурилагдсан дулааны эрчим хүчин чадал: **464 МВт**

Дулааны эрчим хүч үйлдвэрлэлт:

Дулааны эрчим хүчний үйлдвэрлэл ашиглалтад орсоноос хойш жил бүр өсөн нэмэгдэж, сүүлийн 3 жилд дунджаар **761.6-828.7** мянган Гкал дулааны эрчим хүч үйлдвэрлэсэн байна.

Дулааны эрчим хүч үйлдвэрлэлт, борлуулалт:

Дулааны эрчим хүчний үйлдвэрлэл, борлуулалтыг сүүлийн гурван жилээр дараах хүснэгтээр харуулья. Үүнд:

№	Төрөл	2023-2024 он /Гкал/	2024-2025 он /Гкал/	2025-2026 он 2025 оны XI-01-ний байдлаар /Гкал/
1	ДЭХ-ний үйлдвэрлэл	1,045,017.1	1,041,125	1,320,745.0
2	ДЭХ-ний борлуулалт	1,031,493.3	1,025,937.6	1,302,292.01

Орлого: Амгалан дулааны станц ТӨХК-ийн үйлдвэрлэлийн тоо хэмжээ өссөнтэй холбоотойгоор жил дараалан орлого өсөж байна. Үүнд:



ДЭХ-ний орлого (сая.төг)		Үйл ажиллагааны бус орлого (сая. төг)	
2024 он	2025 он	2024 он	2025 оны XI. 01-ний байдлаар
62,110.4	49,607.5	1,114.2	133.1


Тайлбар: Үйл ажиллагааны бус орлогод харилцах дансны хүүний орлого, түрээсийн орлого, үнс борлуулсаны орлого, улсын төсвийн санхүүжилтээр хийгдсэн хөрөнгө оруулалтын ажлын тухайн онд ногдох орлогын дүн зэрэг багтсан.

1.3.ӨМЧ ЭЗЭМШЛИЙН ХУВЬ, УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЭЦ

Монгол Улсын Засгийн Газрын 2015 оны 371 тоот тогтоолоор “Амгалан дулааны станц” ХХК нь “Дулааны IV цахилгаан станц” ТӨХК-ийн охин компани хэлбэрээр анх байгуулагдсан бол Монгол Улсын Засгийн Газрын 2020 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 71 тоот тогтоолоор "Амгалан дулааны станц" ХХК-ийг 100 хувь төрийн өмчит бие даасан хувьцаат компани болгон өөрчилөн зохион байгуулсан.

Компанийн хувьцааны ноогдох хувийн өөрчлөлтийг дараах байдлаар харуулав. Үүнд:






АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-ИЙН ЗАХИРГАА, ХҮНИЙ НӨӨЦИЙН СУДАЛГАА

Удирдлага зохион байгуулалтын бүтэц, ажиллах хүчний талаар:

Амгалан дулааны станц ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020-2025 онуудад баталсан бүтэц, орон тооны дээд хязгаарыг дараах байдлаар харуулав. Үүнд:



Төлөөлөн удирдах зөвлөлийн 2015-2025 оны хооронд баталсан орон тооны дээд хязгаарыг дараах хүснэгтээр харуулав.

№	Өөрчлөлтийн шийдвэрүүд	Орон тооны дээд хязгаар
1	2015 оны 21 дүгээр тогтоол	132
2	2016 оны 31 дүгээр тогтоол	167
3	2017 оны 409 дүгээр тогтоол	176
4	2018 оны 12, 37 дугаар тогтоол	181
5	2019 оны 31 дүгээр тогтоол	186
6	2024 оны 12 дугаар тогтоол	217
7	2024 оны 27 дугаар тогтоол	219

Амгалан дулааны станц ТӨХК нь 4 цех, 5 хэлтсийн зохион байгуулалттай, 3 удирдлага, 47 ИТА, 21 мэргэжилтэн, 149 ажилтан, нийт 219 ажилтантайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

Амгалан дулааны станц ТӨХК-ийн удирдлага, зохион байгуулалтын бүтэцийн нэгжүүдийн үндсэн чиг үүрэг

Бүтэцийн нэгжүүдийн үйл ажиллагааны үндсэн чиг үүрэг

Батлагдсан удирдлага, зохион байгуулалтын бүтэцийн нэгжүүд нь дараах үйл ажиллагааны чиг үүргийг гүйцэтгэнэ. Үүнд:

1.1 Захиргаа, удирдлагын хэлтэс

Компанийн хүний нөөцийн бодлогын хэрэгжилтийг хангах, мэргэжлийн сургалтыг төлөвлөгөө, хэрэгцээний дагуу зохион байгуулах, хөдөлмөрийн харилцааг зохицуулах, хууль эрх зүйн нийцлийг хангуулах, архив-албан хэргийг хууль эрх зүйн хүрээнд хөтлөх, биеийн тамир спорт, урлаг, соёлын арга хэмжээг төлөвлөгөөний дагуу зохион байгуулах.

1.2 Санхүү эдийн засгийн хэлтэс

Компанийн хэтийн болон жилийн бизнес төлөвлөгөө боловсруулах, хэрэгжилтийг хангах, гүйцэтгэлд хяналт тавих, санхүү эдийн засгийн үйл ажиллагаанд судалгаа шинжилгээ хийх, үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлэх бодлого боловсруулан, санхүүгийн менежментийн удирдлагаар хангах, мөнгөн урсгалыг оновчтой төлөвлөх, зардалын гүйцэтгэлд хяналт тавих, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үйл ажиллагааг удирдан, өмч хөрөнгөнд бүртгэлээр хяналт тавьж, удирдлагыг мэдээ мэдээллээр хангах

1.3 Худалдан авах ажиллагааны хэлтэс

Компанийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулах, шаардлагатай аюулгүйн нөөцөөр хангах

14. Хяналтын хэлтэс

Компанийн үйл ажиллагаанд мөрдөгдөх хууль тогтоомж, стандарт, дүрэм, журмын хэрэгжилтийг хангуулах, бодлого хэрэгжүүлэх, гарсан зөрчлийн шалтгааныг тогтоох, давтан гаргуулахгүй байх ажлыг зохион байгуулах, өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавих, ажилтнуудын ажлын хувцас, нэг бүрийн хамгаалах хэрэгслэл, хор саармагжуулах бүтээгдэхүүн, ажлын байр, хоол үйлдвэрлэл, хоолны аюулгүй байдалд тогтмол хяналт тавих, аюулгүй байдлыг хангуулах, ажилтнуудад эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх, өвчлөлтөөс урьдчилан сэргийлэх

1.5. Үйлдвэрлэлийн бодлого, шуурхай ажиллагааны хэлтэс

Дулааны эрчим хүчний үйлвэрлэлийг тасралтгүй, чанартай, найдвартай ажиллуулах бодлого, төлөвлөгөө батлуулан хэрэгжүүлж, үйлдвэр санхүүгийн төлөвлөгөө, горим

параметрийн даалгаварыг биелүүлэх, цех хэсгүүдийн өдөр тутмын ажлын уялдааг зохицуулах, ашиглалт, засварын үйл ажиллагаанд хяналт тавих, шинэчлэл, инновацийн чиглэлээр судалгаа хийж, техник-технологийн хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэх, эрчим хүчний хэмнэлтийн бодлого, төлөвлөгөө хэрэгжүүлэх, програм хангамжийн хөгжүүлэлт, аюулгүй байдлыг хангах, холбогдох хууль, дүрэм, журамд нийцүүлэн гэрээний үндсэн дээр дулаан эрчим хүч борлуулах, нүүрс, ус, цахилгаан эрчим хүч худалдан авах ажлыг гэрээ, тооцооний үндсэн дээр хийх.

1.6. Үйлчилгээ, харуул хамгаалалтын хэсэг, цайны газар

Компанийн тохижилт, гоо зүйг сайжруулах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, байр болон орчны цэвэрлэгээг хариуцах, хүнсний аюулгүй ажиллагааг хангасан, амт чанартай, эрүүл хоол, унд үйлдвэрлэж, ажилтнуудад үйлчилгээ үзүүлэх, ажилтнуудын ажлын хувцас угаах, урагдсан хэсгийн оёх.

1.7. Зуухан цех

Нүүрс, усыг хүлээн авч чанарын шаардлага хангасан дулааны эрчим хүч үйлдвэрлэх, утааны хийг цэвэршүүлэх, үнс шаарга зайлуулах

1.8. Түлш дамжуулах цех

Гэрээний дагуу нийлүүлэгдсэн, чанарын шаардлага хангасан нүүрсээр зуухыг тасралтгүй хангах

1.9. Засварын цех

Хэтийн бодлого боловсруулан тоноглолын засварыг их, дунд урсгал засвар болон төлөвлөгөөт бусаар засварын ажлуудыг гүйцэтгэх, засварын ажилд шаардлагатай металл хийц, эд анги хийх

1.10. Цахилгаан цех

Цахилгаан тоноглол, шугам сүлжээ, технологийн программ хангамжийн найдвартай ажиллагааг хангах, дулааны процессын хэмжих хэрэгслэл, автоматжуулалт, цахилгаан тоноглол, реле хамгаалалт автоматжуулалтын бэлэн байдал хангах.

1.11. Хими хэсэг

Станцын дотоод хэрэгцээ болон технологийн хэрэгцээний усыг боловсруулах, зуухыг технологийн шаардлага хангасан усаар хангах, усны химийн горимд хяналт тавих,

1.12. Авто хүнд машин механизмын хэсэг

Авто машин механизмын бэлэн байлыг хангах, технологийн болон хүн тээвэрт шаардлагатай тээврийн хэрэгслэлээр үйлчилгээ үзүүлэх

Бүтэцийн нэгжүүдийн ажлын байрны тоо 2025 оны XI.01-ний байдлаар

№	Хэлтэс, цех	Ажлын байрны орон тоо
1	Гүйцэтгэх захирал	1
2	Ерөнхий инженер	1
3	Хяналт-үнэлгээ хариуцсан менежер	1
4	Дотоод үйл ажиллагаа хариуцсан менежер	1
5	Дотоод аудитор	1
6	Захиргаа удирдлагын хэлтэс	8
7	Хяналтын хэлтэс	6
8	Үйлдвэрлэлийн бодлого, шуурхай ажиллагааны хэлтэс	9
9	Санхүү, эдийн засгийн хэлтэс	8

10	Худалдан авах ажиллагааны хэлтэс	4
11	Зуухан цех	39
12	Түлш дамжуулах цех	48
13	Засварын цех	22
14	Цахилгаан цех	27
15	Хими хэсэг	14
16	Авто хүнд машин механизмын хэсэг	19
17	Цайны газар	6
18	Үйлчилгээ, харуул хамгаалалтын хэсэг	4
Нийт		219

**АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-ИЙН 2017-2025 ОНУУДЫН АЛБАН
ТУШААЛЫН АНГИЛАЛЫН СУДАЛГАА**

№	Албан тушаалын ангилал	он				
		2017	2019	2021	2023	2025
1	Гүйцэтгэх захирал	1	1	1	1	1
2	Дэд захирал	1	2	1		
3	Хяналт-үнэлгээ хариуцсан менежер					1
4	Дотоод үйл ажиллагаа хариуцсан менежер					1
5	Ерөнхий инженер	1	1	1	1	1
6	Цех, хэлтсийн дарга	8	8	8	8	9
7	Мэргэжилтэн	11	11	10	10	11
8	Инженер техникийн ажилтан	34	34	36	48	37
9	Үйлдвэрлэлийн ажилтан	109	111	116	122	139
10	Үйлчилгээний ажилтан	14	14	12	12	19
Дүн		179	182	185	202	219

АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-ИЙН ХҮНИЙ НӨӨЦИЙН СУДАЛГАА

Амгалан дулааны станц ТӨХК-ийн 2020-2025 оны орон тооны дэлгэрэнгүй судалгаа

№	Бүтэц	2020 он				2021 он				2022 он				2023 он				2024 он				2025 оны VI/01-ний сарын байдлаар			
		ИТА	захиргаа ажилтан	Ажилчин	Нийт	ИТА	захиргаа ажилтан	Ажилчин	Нийт	ИТА	захиргаа ажилтан	Ажилчин	Нийт	ИТА	захиргаа ажилтан	Ажилчин	Нийт	ИТА	захиргаа ажилтан	Ажилчин	Нийт	ИТА	захиргаа ажилтан	Ажилчин	Нийт
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	22	23	24	25	26
1	Захиргаа																								
1.1	Гүйцэтгэх удирдлага		4		4		3		3		2		2		2		2		2		2		4		4
1.2	Үйлдвэрлэлийн бодлого, шуурхай ажиллагааны хэлтэс	4			4	7			7	7			7	8			8	9		9		9			9
1.3	Захиргаа удирдлагын хэлтэс		4	3	7		4	4	8		4	4	8		4	3	7		5	3	8		5	3	8
1.4	Аж ахуй хангамжийн хэлтэс	1	3	4	8	1	4	3	8		4	4	8		4	4	8		4	4	8		4	4	8
1.5	Хяналтын хэлтэс, дотоод аудит	4	1		5	4	1		5	4	1		5	5	1		6	5	1		6	6			6
1.6	Санхүү эдийн засгийн хэлтэс	1	6	2	9		5	2	7	1	5	2	8		5	2	7		5	3	8		5	3	8
	ДҮН	10	18	9	37	12	17	9	38	12	16	10	38				38				41				43

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	22	23	24	25	26
Нийт орон тоонд эзлэх хувь					19.8				20.5				20.4				19.7				20.7				19.6
2	Үндсэн цех нэгж																								
2.1	Түлш дамжуулах цех	7		46	53	7		45	52	7		45	52	7		46	53	6		37	43	6		41	47
2.2	Зуухан цех	8		32	40	7		33	40	7		32	39	7		36	43	6		27	33	7		31	38
2.3	Цахилгаан цех	13		25	38	13		25	38	9		27	36	10		28	38	9		27	36	11		32	43
2.4	Засварын цех																	5		14	19	6		17	23
2.5	Авто хүнд машин механизмын хэсэг	1		17	18	1		17	18	1		17	18	1		16	17	1		16	17	1		18	19
2.6	Төслийн нэгж, цайны газар									3			3	3			3	3		6	9			6	6
Дүн		29		120	149	28		120	148	27		121	148	28		126	154				157				176
Нийт орон тоонд эзлэх хувь					80.1				79.5				79.5				80.2				79.2				80.3

Тайлбар: 1. 2023 онд Амгалан дулааны станцыг 116 МВт-аар өргөтгөсөнтэй холбогдуулан зуух, түлш дамжлагад ажиллах эхний ээлжийн ажилтнуудыг ажилд авч дагалдуулан сургасан.

2. 2024, 2025 онд 116 МВт-ын өргөтгөл бүрэн орж 4 зуух зэрэг галлах болсонтой холбогдуулан зуух, түлш, цахилгаан цех, авто хүнд машин механизмын хэсгийн ажлын байрны тоог нэмэгдүүлсэн учир ажилтны тоо нэмэгдсэн.

3. 2025 онд ТУЗ-өөс 2 менежерийн орон тоо нэмэгдүүлсэн.


4. Амгалан дулааны станц ТӨХК-ийн ажлын байрны тоог тоноглолын тоо, ажилбарууд, Эрчим хүчний салбарт мөрдөгддөг ТАД, ААД, ЭХАДЗААҮД, ЦБАҮМААД-ийн шаардлагуудыг үндэслэн тогтоосон болно.

5. Ажлын байрны нэршлийг тогтоохдоо ХНХ-ын сайдын 2023 оны А/221 дугаар тушаал, 2010 оны YAMAT-08, ISCO-08-г мөрдлөг болгосон.

Ажилтнуудын хүйсийн харьцаа

№	Хүйс	Хүний тоо	Хувь
1	Эрэгтэй	166	76,5%
2	Эмэгтэй	51	23,5%
Ажиллаж байгаа нийт хүний тоо		217	100%

Нийт ажилтнуудын хүйсийн харьцаа




■ эр ■ эм ■

Ажилтнуудын насны ангилал

Компанийн 113 ажилтан буюу 52% нь 31-40 насны залуучууд ажиллаж байна.

№	Насны ангилал	Хүний тоо	Хувиар
1.	21-30 нас	30	14%
2.	31-40 нас	113	52%
3.	41-50 нас	38	17,5%
4.	51 < дээш нас	36	16,5%
5.			
Ажиллаж байгаа нийт хүний тоо		217	100%




Ажилтнуудын боловсролын түвшин

№	Боловсролын түвшин	Хүний тоо	Эзлэх хувь
1.	Бага, бүрэн бус дунд	20	9,2%
2.	Бүрэн дунд	60	27,6%
3.	Тусгай дунд	14	6,5%
4.	Дээд	123	56,7%
Ажиллаж байгаа нийт ажилтны тоо, эзлэх		217	100%

Нийт ажилтнуудын боловсролын мэргэшлийн зэрэг


Монгол Улсын Зөвлөх 4 инженерт үндсэн цалингийн 20%, Мэргэшсэн 15 инженерт үндсэн цалингийн 15%, Мэргэшсэн нягтлан бодогчид үндсэн цалингийн 20%-ийн нэмэгдлийг сар бүр олгодог. Нийт ажилтнуудын 56,7 хувь нь дээд боловсролтой байна.



Эрчим хүчний зэрэг цолтой ИТА, мэргэжилтэн

№	Боловсролын түвшин	Хүний тоо
1.	Монгол Улсын Зөвлөх инженер	4
2.	Мэргэшсэн нягтлан бодогч	1
3.	Мэргэшсэн инженер	15
Нийт		20

Нийт ажилтнуудын эзэмшсэн мэргэжлийн хувьд



Нийт дээд боловсролын мэргэжил эзэмшсэн 123 ажилтнуудаас 82 ажилтан буюу 66,6% нь эрчим хүчний чиглэлээр мэргэжил эзэмшсэн байна.

Ажилтнуудын шилжилт, хөдөлгөөн:

Тайлант онд ажилтнууд өндөр цалинтай байгууллагад шилжин ажиллах, гадаад улсад гэрээгээр ажиллах зэрэг шалтгаанаар ажлаас олноор гарч удаа дараа ажиллах хүчний дутагдалд оруулж байсан. Нэмэгдсэн ажлын байранд дадлага туршлагатай ажилтнуудыг шилжүүлэн ажиллуулсан.

Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөнийг 2024 оны байдлаар онцлон харуулав.

№	Шинээр ажилд орсон		Өөр ажил, албан тушаалд шилжин ажилласан	Ажлаас чөлөөлөгдсөн			Сахилгын шийтгэл ногдуулсан байдал	
	Хугацаагүй хөдөлмөрийн гэрээ байгуулсан	Хугацаатай хөдөлмөрийн гэрээ байгуулсан		Өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн	Тэтгэвэрт	Гэрээний хугацаа дууссан	Сануулах арга хэмжээ	Хөдөлмөр эрхлэлтийн харилцаа цуцлагдсан
01	20	53	34	48	7	5	14	5



АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-ИЙН ҮНДСЭН ҮЙЛДВЭРЛЭЛД БОЛОН ЗАХИРГАА, АЖ АХУЙ, САНХҮҮГИЙН ЧИГЛЭЛИЙН НЭГЖ, АЖЛЫН БАЙРНЫ ТОО /2025 оны байдлаар/


№	Үйл ажиллагааны чиглэл	Нэгж, албан тушалтан	Хүний тоо
1	Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд шууд оролцдог	5	185
2	Захиргаа, аж ахуй, санхүүгийн чиглэлээр	4	32
Дүн		9	217

АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-ИЙН 2023-2024 ОНД ҮЙЛДВЭРЛЭЛИЙН АЖИЛТНУУДЫН ӨӨРИЙН ХҮСЭЛТЭЭР АЖЛААС ЧӨЛӨӨЛӨГДСӨН СУДАЛГАА

№	Он	Үйлдвэрлэлийн ажилтнуудын тоо	Ажлаас чөлөөлөгдсөн үйлдвэрлэлийн ажилтнуудын тоо	Ажлаас гарсан ажилтнуудын эзлэх хувь	Ажлаас чөлөөлөгдсөн ажилтнууд				
					Мэргэжлийн зэрэг			ИТА	Техникийн бусад ажилтан
					III	IV	V		
1	2023 оны XII/31	140	32	23%	10	4	6	7	5
2	2024 оны XII/31	143	53	37%	17	9	7	12	8

АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-ИЙН 2023-2024 ОНД ҮЙЛДВЭРЛЭЛИЙН АЖИЛТНУУДЫН ӨӨРИЙН ХҮСЭЛТЭЭР АЖЛААС ЧӨЛӨӨЛӨГДСӨН ШАЛТГААН


№	Он	Өөрийн хүсэлтгээр ажлаас чөлөөлөгдсөн ажилтны тоо	Ажлаас чөлөөлөгдсөн шалтгаан					
			Гадаад улсад ажиллах	ЭХС-ын үйлдвэр компаниудад шилжин ажиллах	Цалин бага	Уул уурхайн үйлдвэрт ажиллах	Эрүүл мэнд	Тэтгэвэрт гарах
1	2023 оны XII/31	32	4	8	14	4	1	1
2	2024 оны XII/31	53	3	12	21	9	-	8



Тайлбар:

1. Жил бүрийн V/15-аас мөн оны IX/15 хүртэл 4 сарын хугацаанд сул зогсолтонд хамрагдсан ажилтнуудад үндсэн цалингийн 60%-иар олговор тооцож олгодог нь цалин бага учир олговор нь багаар тооцогддог.
2. Газар зүйн хувьд Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт байрладаг учир цалин өндөр тогтоогдсон хотын ЭХС-ын томоохон компаниудад чадвартай, нарийн мэргэжлийн ажилтнууд шилжин ажиллах нь ихэссэн.
3. Гол төлөв компанийн зардлаар сурч мэргэшсэн, чадвар, дадлага туршлага хуримтлуулсан ажилтнууд ажлаас гарч байна. Энэ нь компанийн санхүүгийн хувьд болон дадлага туршлагатай ажилтныг бэлтгэхэд цаг хугацааны хувьд хохиролтой байдаг.
4. Шинээр ажилд орж буй ажилтнууд нь дадлага туршлагагүй байхаас гадна сургаж бэлтгэхэд ихээхэн хугацаа, зардал шаардагдаж байна.
5. Тэтгэвэрт гарах, цалингийн зээл авсан ажилтнуудад сул зогсолтын олговор авах нь ихээхэн хохиролтой учир ажлаасаа гарч өндөр цалинтай ажилд шилжин ажиллах нь гол шалтгаан нь болж байна.

**АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-ИЙН 2019-2024 ОНЫ НИЙТ
АЖЛААС ЧӨЛӨӨЛӨГДСӨН АЖИЛТНУУДЫН СУДАЛГАА**



АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХЖ-ИЙН 2020-2024 ОНЫ ОРОН ТООНЫ ӨӨРЧЛӨЛТИЙН СУДАЛГАА

Он	Шийдвэрийн огноо	Шийдвэр	Орон тооны дээд хязгаар	Үндэслэл
2020	Шийдвэр гараагүй	Ажлын байранд өөрчлөлт ороогүй	186	Ажлын байранд өөрчлөлт ороогүй
2021	Шийдвэр гараагүй	Ажлын байранд өөрчлөлт ороогүй	186	Ажлын байранд өөрчлөлт ороогүй
2022	ТУЗ-ийн 2022 оны 16 тоот тогтоолоор	Дэд захирлын ажлын байрыг 2-оор цөөрүүлж, ажлын байрны тооны дээд хязгаарыг 184 болгон шинэчилсэн.	184	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 5.4 дэх заалтын хэрэгжилтийг хангасан.
2023	ТУЗ-ийн 2023 оны 18 тоот тогтоолоор	Амгалан дулааны станцыг 116 МВт-аар өргөтгөх төсөл хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой төслийн нэгжийг байгуулах, тоноглолын тоо нэмэгдсэнтэй холбоотой тоноглол хариуцсан ээлжийн ажилтны тоог 8-иар нэмэгдүүлэх шаардлага үүссэн.	192	<ol style="list-style-type: none"> 1. Эрчим хүчний Хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах шаардлагаар Эрчим хүчний хэмнэлтийн менежерийн ажлын байр 1-ээр 2. Амгалан дулааны станцыг 116 МВт-аар өргөтгөх төсөл хэрэгжих хугацаанд төслийн инженерийн ажлын байр 3-аар 3. Амгалан дулааны станцыг 116 МВт-аар өргөтгөх төсөл хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Зуухны Туслах тоноглолын машинчийн ажлын байрыг 4-өөр

2024	ТУЗ-ийн 2024 оны 12 тоот тогтоолоор	Амгалан дулааны станцын 116 МВт-ийн өргөтгөлтэй холбоотойгоор ажлын нэмэгдүүлсэн 25 байр	217	<p>1. Галын улсын байцаагч нь тус станцыг галын эрсдэлтэй гэж дүгнээд Галын аюулгүй байдлыг хариуцах ажилтан томилох шаардлага өгсөн тул Галын мэргэжилтний ажлын байр 1-ээр,</p> <p>2. Хяналт, үнэлгээ, засаглал сайжруулах зорилгоор Менежерийн ажлын байрны тоог 2-оор,</p> <p>3. Амгалан дулааны станцын 116 МВт-ийн өргөтгөлтэй холбоотойгоор Зуухны машинчийн ажлын байрыг 4-өөр,</p> <p>4. Амгалан дулааны станцын 116 МВт-ийн өргөтгөлтэй холбоотойгоор Түлш дамжлагын машинчийн ажлын байрыг 4-өөр,</p> <p>5. Амгалан дулааны станцын 116 МВт-ийн өргөтгөлтэй холбоотойгоор зарцуулах нүүрс, ДТ-ний хэмжээ нэмэгдсэн учир Түүхий эдийн няравыг 1-ээр</p> <p>6. Ажилчдын цайны газар шинээр байгуулсан учир цайны газрын ажилчдын тоог 6-аар</p> <p>7.Нүүрсний чанарыг тодорхойлох шаардлагын үүднээс Нүүрсний шинжилгээний лаборантыг 2-оор,</p> <p>8. Амгалан дулааны станцыг 116 МВт-ийн өргөтгөлтэй холбоотойгоор зуухнаас гарах үнсний хэмжээ нэмэгдсэн учир нарийн үнсний машины жолоочыг 2-оор,</p> <p>9. Амгалан дулааны станцыг 116 МВт-ийн өргөтгөлтэй холбоотойгоор ДХХА-ийн засварчны тоог 2-оор,</p> <p>10. Станцын үйлдвэрлэлийн горимын тооцоо хариуцах инженер шаардлагатай учир Горимын хяналт, тооцооны инженерийг 1-ээр,</p>
------	-------------------------------------	--	-----	---

АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-ИЙН 2015-2025 ОНУУДАД НЭГЖҮҮДИЙН ОРОН ТООНЫ ӨӨРЧЛӨЛТИЙН СУДАЛГАА

№	Нэгжийн нэр	Он										
		2015 он	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он	2023 он	2024 он	2025 он
		Ажлын байрны тоо	Ажлын байрны тоо	Ажлын байрны тоо	Ажлын байрны тоо	Ажлын байрны тоо	Ажлын байрны тоо	Ажлын байрны тоо	Ажлын байрны тоо	Ажлын байрны тоо	Ажлын байрны тоо	Ажлын байрны тоо
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13
1	Гүйцэтгэх захирал	1	1	1	1	1	1	1	1	1	1	1
2	Хяналт үнэлгээ, хариуцсан менежер											1
3	Дотоод үйл ажиллагаа хариуцсан менежер											1
4	Ерөнхий инженер	1	1	1	1	1	1	1	1	1	1	1
5	Дэд захирал /санхүү/	1	1	1	1	1	1	1				
6	Дэд захирал /аж ахуй/				1	1						
7	Дотоод аудитор	1					1	1	1	1	1	1
8	ХАБЭАИнженер	1										
9	Хяналтын хэлтэс		3	3	5	5	4	4	4	5	5	5
10	Захиргаа удирдлагын хэлтэс	7	7	7	6	6	11	11	8	7	8	8
11	Ээлжийн инженер	4	4	4	4	4						
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13

12	Горимын хяналт тооцооны инженер		1	1										
13	ҮБШАХ						8	8	7	8	9	9		
14	Төслийн нэгж									3	3	3		
15	Санхүү, эдийн засгийн хэлтэс		7	8	8	9	9	7	7	7	7	8	8	
16	Аж ахуй хангамжийн хэлтэс		8	10	9	10	10	5	5	9	8	14	14	
17	Авто, хүнд машин механизмын хэсэг		12	12	18	18	18	18	18	18	17	19	19	
18	Зуухан цех		29	37	39	40	40	39	39	39	43	38	38	
19	Түлш дамжуулах цех		36	48	48	48	48	52	52	53	53	47	47	
20	Засварын цех											21	21	
21	Нэгдсэн цех	Нэгдсэн цехийн дарга		1	1	1	1	1	1	1	1	1	1	
22		Ахлах инженер										1	1	
23		ТУСПИ	2	3	3	3	3	3	3	3	4	3	3	
24		ДХХА-н хэсэг	5	5	6	6	6	6	6	6	6	10	10	
25		Цахилгааны хэсэг	6	14	14	14	14	14	14	14	12	11	10	10
26		РХА хэсэг		1	2	2	2	2	2	2	2	3	3	3
27		Химийн хэсэг	10	10	11	11	11	11	12	12	12	13	14	14
Нийт			132	167	176	181	181	186	186	184	192	217	219	

АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-ИЙН АЖЛЫН БАЙРНЫ ШИНЖИЛГЭЭ, СУДАЛГАА

Тайлбар:

1. Ажлын байрны шинжилгээ судалгааг 15 мэргэшсэн инженер, Зөвлөх 4 инженер, нийт 58 инженер, техникийн ажилтнуудаас асуумж, ярилцлагын аргаар хийсэн болно.
2. Амгалан дулааны станц ТӨХК-ийн ажлын байрны тоог тоноглолын тоо, ажилбарууд, Эрчим хүчний салбарт мөрдөгддөг ТАД, ААД, ЭХАДЗААҮД, ЦБАҮМААД-ийн шаардлагуудыг үндэслэн тогтоосон болно.
3. Ажлын байрны нэршлийг тогтоохдоо ХНХ-ын сайдын 2023 оны А/221 дугаар тушаал, 2010 оны YAMAT-08, ISCO-08-г мөрдлөг болгосон.

Харьяалах цех, хэлтэс, хэсэг	№	Нэгж хэсгийн албан тушаалын тоо	Албан тушаалын нэр	Ажлын зэрэг	Ажилтны тоо	Ажилтны тоо /нийт/	Хөдөлмөрийн нөхцөл	Ажлын байрны зорилго	Ажлын байрны үндсэн, гол чиг үүрэг /ажлын байранд зайлшгүй хийгдэх үйл ажиллагаа/	Ажлын байрны шаардлага
1	2	3	4	5	6	7	8	9	10	11
	1		Хяналт-үнэлгээ хариуцсан менежер	Удирдлага	1	3	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хууль, Аюулгүй ажиллагааны дүрэм, Техник ашиглалтын дүрэм, Байгаль орчны дүрэм, журам, стандарт, холбогдох хууль тогтоомж, түүнтэй нийцүүлэн гаргасан дүрэм, журам, заавар, стандартын хэрэгжилтийг хангуулах,	1. Хууль, тогтоомж, дүрэм, журам, заавар, стандартыг сурталчлах, хэрэгжилтийг хангуулах, аваари, осол, гэмтэл, саатал, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулснаар үйлдвэрлэлийг аваари, осол, зогсолт, саатал, зөрчилгүй ажиллах нөхцөлийг бүрдүүлэх. 2. Ээлжит болон ээлжит бусаар хууль, дүрэм, журмын сургалт зохион байгуулах. 3. Ажлын байрны зураг авалт, хэмжилт, судалгааг тогтмол хийснээр ажлын байрны болон ажиллах нөхцөл сайжирсан байх	Боловсрол: Бакалавр болон түүнээс дээш боловсролтой байх. Мэргэжил: Эрчим хүчний дээд мэргэжилтэй байх. Мэргэшил: Эрчим хүчний зөвлөх инженер Туршлага: Эрчим хүчний үндсэн үйлдвэрлэлд 5-аас доошгүй жил ажилласан байх.	
1	2	3	4	5	6	7	8	9	10	11

									<p>4. Ажлын байр болон үйлдвэрлэлийн орчинд тохирсон дүрэм, журмыг батлуулж, мөрдүүлэх.</p> <p>5. Аваари, осол, саатал, мэргэжлээс шалтгаалсан өвчлөлийг бүртгэх, үйлдвэрлэлийн орчинд учирч болох аюулыг илрүүлэх, тогтоох, үнэлэх, бууруулах, ажлыг зохион байгуулах.</p> <p>6. Техник ашиглалтын норм, дүрэм, заавар, стандартын мөрдөлтөд хяналт тавих, техник, тоног төхөөрөмжийн аюулгүй байдлыг хангуулах.</p> <p>7. ХАБЭА, Галын аюулгүй байдал, байгаль орчин, техник, тоног төхөөрөмжийн аюулгүй байдлыг хангуулах, норм, дүрэм, заавар, стандартын мөрдөлтөд хяналт</p> <p>8. Компанийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийн тогтолцооны Дотоод аудитын үйл ажиллагааг зохион байгуулах.</p> <p>9. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийн тогтолцоо буюу MNS ISO 45001:2018 стандартын хэрэгжилтийг хангуулах, сайжруулах.</p> <p>10. Ажлын байрны нөхцөлийг сайжруулах зорилгоор ажлын байрны зураг авалт, хэмжилт, судалгааг тогтмол хийснээр ажлын байрны болон ажиллах нөхцөл сайжирсан байх.</p>	
1	1	3	Хяналт-үнэлгээ хариуцсан менежер	Удирдлага	1	3				
1	2	3	4	5	6	7	8	9	10	11

									11. Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад хяналт тавих. 12. ТУЗ-ийн дэргэдэх Дотоод аудитортой хамтарч хяналт, шалгалт хийх, үр дүнг тооцох	
	2		Дотоод үйл ажиллагаа хариуцсан менежер	Удирдлага	1	3		Компанийн дотоод үйл ажиллагааг оновчтой төлөвлөх, төлөвлөгөөний дагуу ажлыг зохион байгуулах.	1. Байгууллагын эрхэм зорилго, зорилтод нийцүүлэн компанийн тохижилт, ногоон байгууламж байгуулах ажлыг зохион байгуулах. 2. Компанийн харуул хамгаалалт, цэвэрлэгээ үйлчилгээний ажил, ажлын хувцас угаалгын ажлыг удирдлагаар хангах. 3. Ажилтнуудад чанартай хоолоор үйлчлэх ажлыг зохион байгуулах. 4. Авто хүнд машин механизмаар үйлчлэх, бэлэн байдал хангуулах. 5. Харуул хамгаалалтын үйл ажиллагаа эрхлэн явуулж байгаа аж ахуйн нэгжтэй байгуулсан гэрээний биелэлтийг хангуулах. 6. Компанийн тохижилтын ажил, ажилтнуудын нормын хувцас угаалга, гадна, доторх орчины цэвэрлэгээ үйлчилгээг удирдлагаар хангах, үүрэг даалгавар өгөх, хяналт тавих. 7. Компанийн автомашины граж, ажилтнуудын авто гражийн зохион байгуулалт, авто, хүнд машин механизмуудын бэлэн байдлыг хангах.	Боловсрол: Дээд боловсролтой Мэргэжил: Төрийн удирдлага, Бизнесийн удирдлага Мэргэшил: Төрийн удирдлага, Бизнесийн удирдлагын магистр Туршлага: Удирдах ажлыг 5-аас доошгүй жил хийсэн байх.
1	2	3	4	5	6	7	8	9	10	11

									8. Станцын хашааны доторхи дэг журмыг хангуулах, камерийн системд хяналт тавих ажлыг хариуцах.	
	3		Ерөнхий инженер	Ерөнхий инженер	1	1	Хэвийн	Үйлдвэрлэлийн хэвийн, найдвартай, тасралтгүй ажиллагааг хангаж эдийн засгийн үр ашигтай, саатал, осол, аварггүй ажиллуулах, компанийн хэмжээнд теникийн бодлогыг хэрэгжүүлэхэд оршино.	<p>1.Үйлдвэрлэлийн өдөр тутмын үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар шууд хангах.</p> <p>2.Үйлдвэрлэлийн хэтийн болон ойрын бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх.</p> <p>3.Үйлдвэрлэл, техникийн үзүүлэлтийг дээшлүүлэх, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх асуудлыг удирдан чиглүүлэх.</p> <p>4.Тоноглолын засварыг хуваарийн дагуу чанартай зохион байгуулах.</p> <p>5.Авари, саатал гарсан, тоноглолын ажиллагаа доголдсон үед шуурхай удирдлагаар хангах.</p> <p>6.Тухайн сард ажиллах үндсэн болон туслах тоноглолын тоо, үйлдвэрийн горим ажиллагаанд хяналт тавих, баталгаажуулах.</p> <p>7.Улсын болон дотоодын хяналтанд байдаг тоног төхөөрөмж, шугам хоолой, даралтат савуудын ээлжит ба ээлжит бус магадлагааны графикыг баталж гүйцэтгэлийг хянах</p> <p>8.Станцын үндсэн ба туслах тоноглолын их болон урсгал засварын графикыг баталж мөрдөлт, чанарт хяналт тавих.</p> <p>9.Тоног төхөөрөмжийн ашиглалтыг сайжруулж, найдвартай ажиллагааг хангахад онцгой анхаарч ажиллах.</p>	<p>Боловсрол:Дээд боловсролтой, магистр буюу түүнээс дээш зэрэгтэй. Мэргэшсэн инженер.</p> <p>Мэргэжил: Дулааны инженер, Цахилгааны инженер, Дулаан цахилгаан станцын инженерээр мэргэжил эзэмшсэн.</p> <p>Мэргэшил: Мэргэжлээрээ 8-аас доошгүй жил ажилласан, ажлын туршлагатай, Мэргэшсэн инженер.</p>
1	2	3	4	5	6	7	8	9	10	11

									<p>10.Байгалийн болзошгүй аюул учрах, том хэмжээний аваари саатал, гал гарах, станцын ээлжит болон хэсэгчилсэн зогсолтын үеэр хийгдэх ажлыг биечлэн зохион байгуулах.</p> <p>11.Технологийн сахилга бат, техник ашиглалтын болон аюулгүй ажиллагааны дүрэм, нэгдсэн сүлжээний дүрмийн хэрэгжилтэд хяналт тавих.</p> <p>12.Өдөр тутмын болон өргөтгөсөн шуурхай зөвлөгөөнийг удирдан явуулах.</p> <p>13.Станцын өдөр тутмын технологийн ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх, шуурхай шийдвэр гаргах.</p> <p>14.Тариф мэргэжлийн лавлах болон ажлын байрны тодорхойлолт мөрдөн ажилладаг ажилтнуудаас мэдлэгийн шалгалт авах, дүгнэлт гаргах.</p> <p>15.Үйлдвэрийн ажлын байрны нөхцөл, эмх цэгцийг сайжруулах.</p> <p>16.Технологийн болон зохион байгуулалтын чиглэлийн бүх график, техник ашиглалт, засварын зааврыг хянаж батлах.</p> <p>17.Тухайн жилийн их болон урсгал засвар, ТЗБАХ-ний төлөвлөгөөг хянах, батлах, хэрэгжилтэд хяналт тавих.</p>	
1	2	3	4	5	6	7	8	9	10	11

Захиргаа удирдлагын хэлтэс	4	8	Захиргаа Удирдлагын Хэлтсийн дарга	Менежер	1	1	Хэвийн	Компанийн хүний нөөцийн стратегийн төлөвлөлт, нэгжүүдийн ажлын үйл явцыг зохион байгуулах, хүн хүчний бүрдүүлэлт, сонголт ба дасан зохицолт, ажиллагсдын үнэлгээ, сургалт ба хөгжил, хөдөлмөрийн харилцааны зохицуулалт, ажилтнуудад үзүүлэх хөнгөлөлт бусад үйлчилгээний ажлыг шуурхай шийдвэрлүүлэх, хүнтэй холбоотой бүхий л үйл ажиллагааг зохицуулах, байгууллагын ажилтнуудын хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх, хүний нөөцийн ашиглалттай холбоотой ажлуудыг хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлэх. Архив, албан хэрэг хөтлөлтийн хэвийн үйл ажиллагаагаар хангах, компанид мөрдөгдөх дүрэм, дотоод журам болон бусад холбогдох дүрэм журам, зааврыг үндэслэлтэй боловсруулж, нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчлэх, байгууллагад мөрдөгдөж буй дүрэм, журмын хэрэгжилтэд хяналт тавихад оршино.	1. Хүний нөөцийн бодлого төлөвлөлт, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах. 2. “Хөдөлмөрийн тухай” хуулийн дагуу гүйцэтгэх захирлын тушаалаар ажилтныг ажилд авах, ажлаас чөлөөлөх болон түр шилжүүлэх ажлыг зохион байгуулах. 3. Байгууллагын эрхэм зорилгыг хангахад шаардлагатай мэргэшсэн, чадварлаг хүний нөөц, хамт олныг бүрдүүлэх, ажиллах хүчний сургалтын бүхий л үйл ажиллагааг хэвийн явуулах, судалгаа шинжилгээний ажлыг хийх. 4. Компанид мөрдөгдөх дүрэм, дотоод журам болон бусад холбогдох дүрэм журмыг үндэслэлтэй боловсруулж, нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчлэх ажлыг зохион байгуулах. 5. Компанид мөрдөгдөж байгаа дүрэм журмуудыг ажилтнуудад мөрдүүлэх, хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулах. 6. Гүйцэтгэх захирлаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтэнд хяналт тавих. 7. Ажиллагсдын сургалтын хэрэгцээний талаарх мэдээллийг цуглуулж, дүн шинжилгээ хийх.	Боловсрол: Дээд боловсролын бакалавраас доошгүй зэрэгтэй байх. Мэргэжил: Эрх зүйч, эрчим хүчний ямар нэгэн мэргэжлийн инженер Туршлага: Салбарт захиргааны чиглэлээр 7-оос доошгүй жил ажилласан байх. Ур чадвар: Тооцоо судалгаа, дүн шинжилгээ хийж үнэлэлт гаргах, ӨОрчин үеийн техник хэрэгслийг ажлын байранд ашиглах, ӨХарилцааны чадвар •Зөвлөгөө өгөх, сургах, дадлагажуулах Танилцуулга хийх ур чадвар ӨГарч буй өөрчлөлтөнд зохицон ажиллах чадвар •Дасан зохицох •Санаачилгатай байх Үр дүнтэй харилцаа тогтоох чадвар.
1	2	3	4	5	6	7	8	9	10	11

									<p>8. Мэргэжлийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн үр дүнтэй чанартай сургалт зохион байгуулах ажлыг зохион байгуулж удирдлагаар хангах.</p> <p>9. Ажилтнуудын дунд урлаг, спортын арга хэмжээг төлөвлөгөө, хөтөлбөр ажилтнуудын санаачилгад тулгуурлан зохион байгуулах.</p> <p>10. Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааны биелэлтэд нь хяналт тавих.</p> <p>11. Захиргаанд ажилтнуудаас хандсан өргөдөл гомдлыг хууль тогтоомж, эрх зүйн актын дагуу шийдвэрлэх.</p> <p>12. Хэлтсийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдлагаар хангах.</p> <p>13. Шинээр ажилд орж буй иргэдийг танилцах сургалтанд хамруулж, жинхлэн ажиллах шалгуур үзүүлэлтэд хяналт тавих ажлыг зохион байгуулах.</p> <p>14. Сургалтын хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулах, ажилтнуудыг бүх шатны сургалтанд хамруулах ажлыг хэрэгжүүлэх, сургалтын байгууллагатай хамтран ажиллах ажлыг зохион байгуулах.</p> <p>15. ЗУХ-ийн сар, жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж батлуулах, батлагдсан төлөвлөгөөний биелэлтийг хангуулах.</p>	<p>• Багаар ажиллах Тусгай шаардлага: Ёс зүйн хэм хэмжээг хэлбэрэлтгүй сахих, байгууллагын нууц хадгалах</p>
1	2	3	4	5	6	7	8	9	10	11

									<p>17. Амгалан дулааны станцын жилийн төлөвлөгөөг боловсруулах ажлыг нэгтгэн зохион байгуулах, батлуулах, хэрэгжилтэд хяналт тавих ажлыг зохион байгуулах.</p> <p>18. Байгууллагын цех, хэлтэс, хэсгийн жилийн ажлын тайлан хамгаалуулах ажлыг зохион байгуулах.</p> <p>19. Шагналд нэр дэвшүүлэх, тодорхойлох ажлыг зохион байгуулах.</p> <p>20. Ажилтнуудын хувийн хэрэг, тоо бүртгэл хөтлөх, ажиллах бүрэлдэхүүний болон хөдөлгөөний тайлан гаргах ажлыг зохион байгуулах.</p> <p>21. Ажилтнуудыг ажилд авах, чөлөөлөх, халах, сахилгын шийтгэл ногдуулах, цалин нэмэгдүүлэх, нэмэгдлийн хэмжээг тогтоох, мэргэжлийн зэрэг олгох, шилжүүлэх ажлыг зохион байгуулах.</p> <p>22. Ажилтнуудын цагийн ирц, ашиглалтад тогтмол хяналт тавих, ажлын цаг ашиглалтыг сайжруулах ажлыг зохион байгуулах.</p> <p>23. Байгууллагын удирдлага зохион байгуулалтын бүтэц, орон тоо тогтоолгох төсөл боловсруулан удирдлагадаа танилцуулах, батлагдмагц мөрдөх ажлыг зохион байгуулах.</p> <p>24. Нийт ажилтнуудын эрүүл мэндийн хугацаат үзлэгийг зохион байгуулах.</p>	
1	2	3	4	5	6	7	8	9	10	11

									<p>25.Ажилтнуудыг шагнаж урамшуулах, боловсон хүчний өөрчлөлт, тогтвор суурьшилгүй байгаагийн шалтгааныг судлах, боловсон хүчний талаар компаниас хийвэл зохих бүх төрлийн судалгаа, тайланг гаргуулах, мэргэжлийн удирдлагаар хангана.</p> <p>26.Гүйцэтгэх захирлын тушаал шийдвэрийн төсөл хэрхэн боловсруулагдаж, хянагдаж, хууль, дүрэмд нийцэж байгаа эсэх, мөн биелэлтэд хяналт тавих.</p> <p>27.Хамтын гэрээний хэрэгжилтийг хангах.</p> <p>28.Хэлтсийн ажилтнуудын сарын төлөвлөгөөг батлуулж, биелэлтэд хяналт тавьж, өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулж, удирдлагаар хангах</p>	
	5		Ахлах мэргэжилтэн	Мэргэжилтэн	1	4	Хэвийн	Мэргэшсэн чадварлаг хүний нөөцийг бүрдүүлэх.	<p>1. Хүний нөөцийн бодлогын баримт бичгийн төсөл боловсруулах, хэрэгжилтийг хангуулах.</p> <p>2.Ажилтны шилжилт хөдөлгөөнийг тухай бүр нь хууль, журам, гэрээнд заагдсаны дагуу зохион байгуулах.</p> <p>3.Тухайн жилд төлөвлөгдсөн сургалтыг үр дүнтэй, чанартай зохион байгуулах.</p> <p>4.Дүрэм журмын боловсруулалт, нэмэлт өөрчлөлт, шинэчлэлтэд хяналт тавих.</p> <p>5.Удирдлагаас өгсөн үүрэг даалгаварыг биелүүлэх.</p>	<p>Боловсрол: Дээд боловсролын бакалавраас доошгүй зэрэгтэй байх.</p> <p>Мэргэжил: Эрчим хүчний ямар нэгэн мэргэжлийн инженер, эрх зүйч</p> <p>Туршлага: Эрчим хүчний салбарт 5-аас доошгүй жил ажилласан байх.</p>
1	2	3	4	5	6	7	8	9	10	11

									<p>6.Архив, албан хэрэг хөтлөлтөд хяналт тавих.</p> <p>7.Ажилтнуудыг ажилд авах, ажлаас чөлөөлөх, хөдөлмөрийн гэрээ цуцлах, сахилгын шийтгэл ногдуулах тушаалын төсөл боловсруулж, хянуулах.</p>	<p>Ур чадвар: ØТооцоо судалгаа, дүн шинжилгээ хийж үнэлэлт гаргах, Ø Харилцааны чадвар</p> <ul style="list-style-type: none"> • Зөвөлгөө өгөх, сургах, дадлагажуулах <p>Ø Танилцуулга хийх ур чадвар</p> <p>Ø Гарч буй өөрчлөлтөнд зохицон ажиллах чадвар</p> <ul style="list-style-type: none"> • Дасан зохицох • Санаачилгатай байх <p>Ø Үр дүнтэй харилцаа тогтоох чадвар</p> <ul style="list-style-type: none"> • Багаар ажиллах <p>Тусгай шаардлага: Ёс зүйн хэм хэмжээг хэлбэрэлтгүй сахих, байгууллагын болон хувь хүний нууц хадгалах.</p>
	6		Хуулийн мэргэжилтэн	Мэргэжилтэн	1		Хэвийн	Компаниас гарч байгаа баримт бичиг, Гүйцэтгэх захирлын тушаалыг хууль эрх зүйн хүрээнд боловсруулж, биелэлт хэрэгжилтэнд хяналт тавьж ханган аижллахад оршино.	<p>1.Компанийн дотоод журам бусад дүрэм журмыг холбогдох хууль тогтоомжийн дагуу боловсруулж, нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчлэх захирлын зөвлөлийн хуралд хэлэлцүүлэх.</p> <p>2.Компанид мөрдөгдөж байгаа дүрэм журмуудыг ажилтнуудад мөрдүүлэх, хэрэгжилтийг хуралд хэлэлцүүлэх.</p>	<p>Боловсрол: Дээд боловсролын бакалавраас доошгүй зэрэгтэй.</p> <p>Мэргэжил: Эрх зүйч</p> <p>Мэргэшил: Хөдөлмөрийн эрх зүй, захиргааны эрх зүй</p>
1	2	3	4	5	6	7	8	9	10	11

									<p>3.Гүйцэтгэх захирал, Ерөнхий инженер, ЗУХ-ээс өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтэд хяналт тавьж ажиллах.</p> <p>4.Хөдөлмөрийн дотоод журмын төсөл боловсруулах, батлуулах, өөрчлөх түүнийг сахиулах ажлыг зохион байгуулах.</p> <p>5.Компанийн хэмжээнд дэг журмыг хангуулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хөдөлмөрийн сахилга батыг сайжруулах арга хэмжээг зохион байгуулах.</p> <p>6.Хууль, зарлиг дээд байгууллага болон байгууллагын тушаалын биелэлтийг нэгтгэн гаргаж холбогдох газруудад хүргүүлэх.</p> <p>7. Хууль, тогтоомж, нийтлэг мөрдөх эрх зүйн актын эмхтгэл лавлагааны баримт бичгийн сан бүрдүүлж ажилтнуудыг мэдээлэл авах нөхцөл бололцоогоор хангах.</p> <p>8.Эрх бүхийн албан тушаалтнуудын хөрөнгө орлогын мэдүүлгийг хугацаанд нь тухай бүр АТГ-т явуулах.</p> <p>9.Авлигын эсрэг ажиллах жилийн төлөвлөгөө гаргаж, хэрэгжүүлэх.</p> <p>10.Байгууллагыг төлөөлж шүүх хуралд оролцох.</p>	<p>Ур чадвар: ØТооцоо судалгаа, дүн шинжилгээ хийж үнэлэлт гаргах, Ø Харилцааны чадвар • Зөвөлгөө өгөх, сургах, дадлагажуулах Ø Танилцуулга хийх ур чадвар Ø Гарч буй өөрчлөлтөнд зохицон ажиллах чадвар • Дасан зохицох • Санаачилгатай байх Ø Үр дүнтэй харилцаа тогтоох чадвар • Багаар ажиллах Тусгай шаардлага: Ёс зүйн хэм хэмжээг хэлбэрэлтгүй сахих, байгууллагын болон хувь хүний нууц хадгалах.</p>
	7		Хүний нөөцийн менежер	Мэргэжил тэн	1		Хэвийн	Хүний нөөцийн бодлого төлөвлөлт, хэрэгжилтийг хангах. шаардлага хангасан ажиллах хүчнээр тасралтгүй хангах.	<p>1. Боловсон хүчний бүрэлдэхүүн, хөдөлгөөний тайлан, ажлын байрнуудын тодорхойлолт гаргах, хөдөлмөрийн гэрээ байгуулах ажлыг зохион байгуулах,</p>	<p>Боловсрол: Дээд боловсролын бакалавраас доошгүй зэрэгтэй байх.</p>
1	2	3	4	5	6	7	8	9	10	11

									<p>батлагдсан орон тооны дагуу судалгаа гаргах, хувийн хэргийн материал бүрдүүлэх, баяжилт хийх, ажилд орох, ажлаас гарах тушаалын төслийг боловсруулж, хянуулж, батлуулах.</p> <p>2. Ажилтнуудын бүртгэл хөтлөх, ажилтнуудад тодорхойлолт олгох, “Хөдөлмөрийн тухай” хуулийн дагуу гүйцэтгэх захирлын тушаалаар ажилтныг ажилд авах, ажлаас чөлөөлөх.</p> <p>3. Ажилтны хувийн хэргийг бүрдүүлэх, хөтлөх, нууцлан хадгалах.</p> <p>4. Ажилд орох хүсэлтэй иргэдийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулж, эрх бүхий удирдлагуудад санал болгох.</p> <p>5. Хүний нөөцийн ажлын тайлан гаргах.</p> <p>6. Ажилд орох хүсэлтэй иргэдийн материалыг хүлээн авч бүртгэлжүүлэх.</p> <p>7. Шинээр ажилд авах ажилчидын бичиг баримтыг бүрдүүлэх. 8. Эмнэлгийн хуудасны ажилласан хугацааг үнэн зөв бөглөж СЭЗХ-т хүлээлгэн өгөх.</p> <p>9. Ажилтнуудын ээлжийн амралтын хуваарийг тушаалаар гаргаж, батлуулан, хуваарийн дагуу ээлжийн амралтын мэдэгдэх хуудсаар ажилтан бүрээр амралтын тооцоог гаргаж, СЭЗХ-т хуудсыг өгөх.</p>	<p>Мэргэжил: Эрх зүйч, инженер, төрийн удирдлага, бизнесийн удирдлага зэрэг аль нэг мэргэжил эзэмшсэн байх.</p> <p>Туршлага: Эрчим хүчний салбарт 5-аас доошгүй жил ажилласан байх.</p> <p>Ур чадвар: Тооцоо судалгаа, дүн шинжилгээ хийж үнэлэлт гаргах, Харилцааны чадвар, Зөвөлгөө өгөх, сургах, дадлагажуулах</p> <p>Танилцуулга хийх ур чадвар</p> <p>Гарч буй өөрчлөлтөнд зохицон ажиллах чадвар</p> <p>Дасан зохицох Санаачилгатай байх</p> <p>Үр дүнтэй харилцаа тогтоох чадвар</p> <p>Багаар ажиллах Тусгай шаардлага: Ёс зүйн хэм хэмжээг хэлбэрэлтгүй сахих, байгууллагын болон хувь хүний нууц хадгалах.</p>
1	2	3	4	5	6	7	8	9	10	11

									<p>10. Ажиллах хүчний хөдөлгөөний бүртгэлийг тухай бүр нь хийх.</p> <p>11. Тэтгэвэр, группт гарах хүмүүсийн материалыг үнэн зөв бүрдүүлж тушаал шийдвэр гаргуулах.</p> <p>14. Ажилтнуудад тодорхойлолт гаргаж өгөх.</p> <p>15. Хүний нөөцийн жилийн эцсийн тайлан мэдээ гаргаж мэдээлэх.</p> <p>11. Ажлаас чөлөөлөгдсөн ажилтнуудын ээлжийн амралтын тооцоог хийж, мэдэгдэх хуудсыг СЭЗХ-т өгөх.</p> <p>12. Ажилтнуудын ажилласан хугацааг нотлох баримт дээр үндэслэн үнэн зөв тооцон бодох, хөтлөх.</p> <p>13. Ажилтанд үнэмлэх олгох, ажлаас гарах ажилтнаас үнэмлэхийг нь хурааж авах.</p> <p>14. Ажлаас чөлөөлөгдсөн ажилтны тойрох хуудас, ажил хүлээлцэх акт, анкетыг архивлан, архивт шилжүүлэх.</p> <p>15. Ажиллагсдын гэрийн хаягийн бүртгэл хөтлөх, баяжуулах, хөдөлгөөн хийх.</p> <p>16. Ажиллагсдыг анкетаар судалж, дэлгэрэнгүй судалгаа гаргах.</p> <p>17. Ажлын талаар хэлтсийн даргад мэдээлэл өгч асуудлыг танилцуулж чиглэл авах.</p> <p>18. Ажилтнуудтай хөдөлмөрийн гэрээ байгуулах, өөрчлөлт оруулах, асуудлыг хариуцах.</p> <p>19. Хүний нөөцийн программыг хөтөлж, баяжуулалтыг хийх.</p>	
1	2	3	4	5	6	7	8	9	10	11

									20. Ажилтнуудын цагийн ирц, ашиглалтад тогтмол хяналт тавих, ажлын цаг ашиглалтыг сайжруулах ажлыг зохион байгуулах, цаг ашиглалтад гэнэтийн үзлэг шалгалт хийх, гарсан зөрчилд хариуцлага тооцуулах асуудлыг хариуцах. 21. Ажилтнуудын цагийн баланс, тодорхойлолтыг хянах	
	8		Сургалт, судалгааны мэргэжилтэн	Мэргэжилтэн	1		Хэвийн	Амгалан дулааны станцын гадаад болон дотоод сургалтын бүхий л үйл ажиллагааг хэвийн явуулж, шаардлагатай судалгаа шинжилгээний ажлыг чанарын өндөр түвшинд хийж гүйцэтгэх.	1. Компанийн нийт ажилтнуудын сургалтын жилийн төлөвлөгөөг гарган батлуулах. 2. Ажиллагсдын мэргэжлийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн үр дүнтэй, чанартай сургалт зохион байгуулах. 3. Ажилтнуудын сургалтын хэрэгцээний талаарх мэдээллийг цуглуулж, дүн шинжилгээ хийх. 4. Хариуцсан ажлын чиглэлээр ажлын тайлан гаргах. 5. Шинээр ажилд орж буй иргэдийг бүртгэн авч танилцуулах сургалт зохион байгуулж, хамруулах. 6. Шинээр ажилд орж буй иргэнд туршилтын буюу дагалдан суралцах хугацаанд зайлшгүй сурсан байх сургалтын хөтөлбөр өгөх. Тухайн цех, хэсгийн илүү дадлага туршлагатай гэж үзэх ажилтанд дагалдангаар ажиллах гэрээ байгуулж тухайн ажилтныг дагалдангаар ажиллуулах.	Боловсрол: Дээд боловсролын бакалавраас доошгүй зэрэгтэй байх. Мэргэжил: Төрийн удирдлага, Эдийн засагч, Эрх зүйч, Мэргэшил Туршлага: Эрчим хүчний салбарт 5-аас доошгүй жил ажилласан байх Ур чадвар: Ø Тооцоо судалгаа, дүн шинжилгээ хийж үнэлэлт гаргах, Ø Орчин үеийн техник хэрэгслийг ажлын байранд сайн ашиглах, Ø Харилцааны чадвар • Зөвөлгөө өгөх, сургах, дадлагдажуулах Ø Танилцуулга хийх Ур чадвар
1	2	3	4	5	6	7	8	9	10	11

									<p>7. Шинээр ажилд орсон дагалдан ажилтныг гурван сар хүртэлх хугацаанд хөтөлбөрийн дагуу суралцуулж бүх талын шалгалтанд хамруулна. Ажилд чадварын хувьд тэнцээгүй ажилтныг ажлаас чөлөөлөх шалгалтын дүнгийн тодорхойлолтыг шууд удирдлагадаа өгч ажлаас чөлөөлүүлэх асуудлыг шийдвэрлүүлэх.</p> <p>8. Дагалдан ажилтны зэрэг олгох сургалт зохион байгуулах, сургалтанд хамрагдах зэрэг дүрэм, журмыг боловсруулан батлуулж, мөрдөн ажиллах.</p> <p>9. Сургалтын хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулах, ажилтнуудыг бүх шатны сургалтанд хамруулах ажлыг хэрэгжүүлэх, сургалтын байгууллагатай хамтран ажиллах.</p> <p>10. Байгууллагын сургалтын танхим хариуцах.</p> <p>11. Захиргаа удирдлагын хэлтсийн дотоод баримт бичиг цэгцлэх, тайлан мэдээ гаргах ажлыг хариуцаж хийнэ.</p> <p>12. Амгалан дулааны станцын жилийн, хэтийн төлөвлөгөөг боловсруулах ажлыг нэгтгэх, шууд удирдлагаар хянуулах, батлуулах.</p>	<p>Ø Гарч буй өөрчлөлтөнд зохицон ажиллах чадвар</p> <p>• Дасан зохицох Санаачилгатай байх</p> <p>Ø Үр дүнтэй харилцаа тогтоох чадвар</p> <p>• Багаар ажиллах</p>
1	2	3	4	5	6	7	8	9	10	11

									<p>1.Байгууллагад ирсэн бичгийг хүлээн авах, бүртгэх, цохолтоор холбогдох ажилтанд хүлээлгэн өгөх, хариутай бичгийн шийдвэрлэлтэд хяналт тавьж ажиллах.</p> <p>2.Байгууллагаас явуулах бичгийг хянуулах, батлуулах, бүртгэх, эх хувийг холбогдох байгууллагад хүргэх асуудлыг зохион байгуулах.</p> <p>3.Албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр гарсан дүрэм, журмын дагуу баримт бичгийг зохион бүрдүүлэх, байгууллагын хэмжээнд мөрдүүлж ажиллах, баримт бичгийн нууцыг хадгалах.</p> <p>4.Өөрийн шууд хариуцсан тухайн жилийн баримтуудыг архивлах.</p> <p>5.Байгууллагын бичиг хэргийн тэмдэг, дардасуудыг хариуцах.</p> <p>6.Албан хэргийн хэвлэмэл хуудсыг захиалах, хэвлүүлэх, зарцуулалтад хяналт тавих.</p> <p>7.Байгууллагын албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд үүссэн баримтуудын эрэлт хайлтыг түргэн шуурхай, боловсронгуй болгох зорилгоор баримтуудыг цахим хэлбэрт шилжүүлэх.</p> <p>8.Байгууллагад ирсэн явуулсан бичгийн мэдээ, тайланг улирал бүр гаргаж удирдлагад танилцуулах.</p> <p>9. Гүйцэтгэх захирлын үндсэн үйл ажиллагааны чиглэлээр болон боловсон хүчний чиглэлээр гаргасан тушаалын</p>	<p>Боловсрол: Дээд боловсролын бакалавраас доошгүй зэрэгтэй байх.</p> <p>Мэргэжил: Эрх зүйч, Архив-бичиг хэргийн мэргэжилтэн</p> <p>Мэргэшил: Архив, албан хэрэг хөтлөлтөөр мэргэшсэн байх</p> <p>Ур чадвар: Багаар ажиллах чадвартай</p> <p>Тусгай шаардлага: Ёс зүйн хэм хэмжээг сахих, байгууллагын болон хувь хүний нууц хадгалах.</p>
1	2	3	4	5	6	7	8	9	10	11

									<p>биелэлтийн мэдээ, тайланг сар, улирал, жилээр гаргаж удирдлагад танилцуулах.</p> <p>10.Тушаал, албан бичгийн хөтлөлт, тоо, ширхэг, бичилтийн стандарт, хадгалалт, хамгаалалттай холбоотой бүхий л асуудлыг байгууллагын өмнө хариуцна.</p> <p>11.Тушаал, ирсэн, явсан бичгийн бүртгэлийг тухай бүр нь хөтлөх.</p> <p>12.Албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр байгууллагын ажилтнуудад арга зүйгээр хангаж ажиллах, ажлын байран дээр болон мэргэжлийн байгууллагатай хамтарч сургалт зохион байгуулах.</p> <p>13.Байгууллагын архивт баримт хүлээн авах, архивын баримтын хадгалалт, хамгаалалт, ашиглалтыг шууд хариуцах, БНШК-ын үйл ажиллагааг хугацаанд нь зохион байгуулах, төрийн архивт баримт шилжүүлэх.</p> <p>14.Архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх.</p> <p>15.Архивт хадгалагдаж буй задгай баримтыг нягтлан шалгаж, эмхлэн цэгцэлж, гэмтэлтэй баримтыг сэлбэн засах, сэргээн шинэтгэх.</p>	
	10		Захирлын туслах	Ажилтан	1		Хэвийн	Гүйцэтгэх захирлын өдөр тутмын үйл ажиллагаанд туслах, өргөдөл гомдлыг хүлээж авах, хариу өгөх, шийдвэрлүүлэх.	<p>1.Дээд байгууллагаас ирүүлсэн тушаал, шийдвэр албан даалгавар, үүргийн биелэлтийг гаргах.</p> <p>2.Компанийн хэмжээнд хурал зөвлөгөөн зарлах, холбогдох албан тушаалтныг цуглуулах.</p>	Боловсрол: Дээд боловсролтой бакалавраас доошгүй зэрэгтэй байх
1	2	3	4	5	6	7	8	9	10	11

									<p>3.Удирдлагын шийдвэр, үүрэг даалгаварыг холбогдох албан тушаалтанд тараах, танилцуулах, биелэлтийг гаргах.</p> <p>4. Гүйцэтгэх захирал, Ерөнхий инженер нартай уулзах зочдыг зөвшөөрлөөр уулзуулах.</p> <p>5.Удирдлагаас өгсөн албан даалгаварыг утсаар болон бичгээр дамжуулан гүйцэтгэлийг хугацаанд нь мэдээлэх.</p> <p>6.Иргэд, ажилтнуудаас ирсэн өргөдөл, гомдлыг хүлээн авч бүртгэлжүүлэх, удирдлагад танилцуулж, хуулийн хугацаанд хариу өгөх.</p> <p>7.Гүйцэтгэх захирлын үр дүнгийн гэрээ боловсруулах, батлуулах, хэрэгжилтэнд хяналт тавих, тайлагнах асуудлыг хариуцах.</p> <p>8.Гадаад, дотоодод албан томилолтоор явах ажилтанд томилолтын хуудас олгох, үр дүнг тайлагнуулах.</p> <p>9.Гүйцэтгэх захирлын зөвлөлийн хурлын бэлтгэл хангах, хурлыг журмын дагуу зохион явуулах, гэмдэглэл хөтлөх, дуу хураагчаар бичлэг хийх, шийдвэрийн биелэлтэд хяналт тавих, мэдээлэх.</p> <p>10.Өргөтгөсөн шуурхай зөвлөгөөний бэлтгэл хангах, гэмдэглэл хөтлөх, журмын дагуу зохион байгуулах, шийдвэрийн биелэлтэд хяналт тавих.</p>	<p>Мэргэжил: Эдийн засагч, Эрх зүйч</p> <p>Мэргэшил: Архив, албан хэрэг хөтлөлтийн сургалтанд хамрагдсан байх.</p> <p>Ур чадвар: Ө Архив бичиг хэргийг стандартын дагуу хөтлөдөг байх.</p> <p>Ө Харилцааны түвшиний өндөр соёлтой байх</p> <p>Тусгай шаардлага: Ёс зүйн хэм хэмжээг сахих, байгууллагын нууц, хувь хүний нууц хадгалах.</p>
1	2	3	4	5	6	7	8	9	10	11

									<p>11.Байгууллагын удирдлага гарын үсэг зурсан болон бичиг хэргийн шаардлага хангасан баримтанд тэмдэг дарах, байгууллагын тэмдэг түших.</p> <p>12.Хурлын танхимын бүрэн бүтэн байдал, цэвэрлэгээ үйлчилгээ, хурал хийгдэх бэлэн байдлыг хангах.</p>	
	11		Спорт, урлаг хариуцсан зохион байгуулагч	Ажилтан	1		Хэвийн	<p>Ажилтнуудын чөлөөт цагийг эрүүл, зөв боловсон өнгөрөөх зорилгоор ажилтнуудын дунд урлаг, спортын арга хэмжээг төлөвлөгөө, хөтөлбөр, ажилтнуудын санаачилгад тулгуурлан зохион байгуулах.</p>	<p>1. Ажилтнуудын дунд урлаг, спортын арга хэмжээг төлөвлөгөө, хөтөлбөр, ажилтнуудын санаачилгад тулгуурлан зохион байгуулах.</p> <p>2. Улс, хот, салбарын болон хамтран ажилладаг байгууллагуудын дунд зохион байгуулагдах урлаг, спортын арга хэмжээнд хамт олноо бэлтгэх, амжилттай оролцуулах.</p> <p>3. Тэмдэглэлт баяр ёслолын арга хэмжээг чанартай зохион байгуулах.</p> <p>4. Спорт заал, фитнесийн заал, хурлын заал, спорт заалны “нийтийн бие засах өрөө”-ний эд хогшилын бүрэн бүтэн, эмх цэгцтэй байдлыг хариуцах.</p> <p>5. Фитнесийн заал, гадна талбайн цэвэрлэгээ үйлчилгээг хариуцах.</p> <p>6. Чөлөөт тоглолт зохион байгуулах, ажилтнуудын дунд урлаг, спортын секц, дугуйлан хичээллүүлэх.</p> <p>7. Ажилтнуудын алжаал тайлах ажлыг зохион байгуулах, ажилтнуудыг эрүүлжүүлэх.</p> <p>8. Спорт, урлагийг ажилтнуудад таниулах, сурталчилах.</p>	<p>Боловсрол: Бүрэн дунд болон түүнээс дээш боловсролтой байх.</p> <p>Мэргэжил: Багш, дасгалжуулагч, тамирчин</p> <p>Ур чадвар: Олон нийтийн ажил зохион байгуулах, урлаг, спортын авьяастай байх</p> <p>Ø Баяр ёслолын арга хэмжээг зохион байгуулах чадвар эзэмшсэн байх.</p> <p>Ø Харилцааны чадвар</p> <ul style="list-style-type: none"> • Зөвөлгөө өгөх, сургах, дадлагажуулах Ø Танилцуулга хийх ур чадвар • Хариуцсан ажлын тухай тайлагнах Санаачилгатай байх • Багаар ажиллах
1	2	3	4	5	6	7	8	9	10	11

1	2	3	4	5	6	7	8	9	10	11

								зорилтыг биелүүлэх, зуухны горим болон тооцоот чадлыг бүрэн ашиглах, зуух галлах.		машинчийн машинчийн сургалт, даралтат савыг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрмийн сургалтад тус тус хамрагдаж үнэмлэхжсэн, тоноглолын гэмтэлийг илрүүлэх чадвар эзэмшсэн, тус станцад 1-ээс доошгүй жил ажилласан туршлагатай, Тулах тоноглолын машинчаар 7-оос дээш жил ажилласан байх, гал унтраагуул ашиглах чадвартай, хараа, сонсгол, амьсгалын замын болон зүрх судасны архаг үрэвсэл, харшилгүй, эрүүл чийрэг, сэтгэцийн ямар нэгэн өөрчлөлтгүй байх.
	53		Тулах тоноглолын машинч	IV	8		Хүнд	Зуухны туслах тоноглолын хэвийн найдвартай ажиллагааг хангах.	Зуухны тоноглолыг горимоор ажиллуулах, явуулах, зогсоох, туршихад зуухны машинчийн удирдлагад ажиллах, дизель түлш залгах, юүлэх схем, асаагуурын төхөөрөмж, усны шугамд химийн бодис оруулах тоноглол, үлээлгийн систем, халах гадаргуугийн үлээлэг, техникийн ус, шахсан хийн схем зэрэг зуух болон зуухны туслах тоноглолын хэвийн найдвартай ажиллагааг хангах зуухны	Бүрэн дунд ба баклавраас дээш боловсролтой, мэргэжлийн үнэмлэх авсан, даралтат савыг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрмийн сургалтад хамрагдаж үнэмлэхжсэн байх, хараа, сонсгол, амьсгалын замын
1	2	3	4	5	6	7	8	9	10	11

									хэсгийн дулааны схемд сэлгэн залгалт хийх, тоног төхөөрөмжийн ажиллагааны үед гарсан гэмтлийг илрүүлж арилгах, гарсан аваарийг устгахад оролцох ба ээлжийн хугацаандаа ээлжийн даргын шууд удирдлагад ажиллана.	болон зүрх судасны архаг үрэвсэл, харшилгүй, эрүүл чийрэг, сэтгэцийн ямар нэгэн өөрчлөлтгүй байх
	54		Насосны машинч	III	4		Хүнд	Зуухны туслах тоноглол насосны хэвийн найдвартай ажиллагааг хангах.	Насос, хаалт арматорын бүрэн бүтэн байдлыг хариуцан, зуухны ус хангамжийг тасралтгүй хангаж ажиллах, шуурхай ажиллагааны арга хэмжээнүүдийг Станцын ээлжийн инженер, зуухны ээлжийн дарга нарын шууд удирдлага, заврын дагуу гүйцэтгэнэ.	Бүрэн дунд ба түүнээс дээш боловсролтой, насосны машинчийн мэргэжлийн үнэмлэх авсан, даралтат савыг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрмийн сургалтад хамрагдаж үнэмлэхжсэн байх, хараа, сонсгол, амьсгалын замын болон зүрх судасны архаг үрэвсэл, харшилгүй, эрүүл чийрэг, сэтгэцийн ямар нэгэн өөрчлөлтгүй байх.
	55		Үйлдвэрийн цэвэрлэгээ үйлчилгээний ажилтан	Үйлчилгээний ажилтан	2	3	Хүнд	Хариуцсан талбайн цэвэрлэгээг тогтмол хийж, ажиллагсдыг эрүүл орчинд ажиллах нөхцөл боломжоор хангах.	1.Хуваарьт талбайд батлагдсан хувиарын дагуу цэвэрлэгээг өдөр бүр чанарын өндөр түвшинд цэвэрлэх. 2.Зуухан цехийн эрэгтэй, эмэгтэй бие засах өрөөний цэвэрлэгээг өдөр бүр хийж, гүйцэтгэх. Хуваарьт талбайн тохижилт соёлжилт, эд хөрөнгийг шууд хариуцах. 3.Байгууллагаас тавьж олгосон хувин, шүүр, шалны мод, арчих	Боловсрол: Бага буюу түүнээс дээш буюу бичиг үсгийн бүрэн боловсролтой байх. Мэргэжил: Мэргэжил харгалзахгүй. Мэргэшил: Шаардахгүй
1	2	3	4	5	6	7	8	9	10	11

									материал, цэвэрлэгээний болон ариутгах бодис зэргийг нормын дагуу хэрэглэх. 4.Цэвэрлэгээ үйлчилгээндээ дэвшилттэй арга хэлбэрийг аль болохоор нэвтрүүлж, үйлчилгээний соёлч, чанарыг эрхэмлэн ажиллах.	
	56		Худгийн эргүүл	Ажилтан	1		Хүнд	Станцын технологийн үйл ажиллагааны найдвартай ажиллагааг хангах зорилгоор түүхий усны зарцуулалтаас шалтгаалан гүний худгуудын насосыг залгаж, салгах, шугам хоолой, худгийн өмч хөрөнгөнд тогтмол үзлэг шалгалт хийж, хяналт тавих.	1.Худаг №4, 5, 7, 8 болон шугам хоолойд тогтмол үзлэг, эргэлт шалгалтыг хийж, хяналт тавьж, мэдээлнэ. 2.Худаг №4, 5, 7, 8-ын бүрэн бүтэн байдлыг хариуцаж, гарсан зөрчилийг шуурхай арилгах арга хэмжээ авч ажиллана. 3.Худаг №4, 5, 7, 8-ын болон шугам хоолойн ойр орчины тохижилт, соёлжилтыг шууд хариуцна. 4.Худгийн дотор болон гадна зам, талбайн цэвэрлэгээ үйлчилгээг тогтмол хийж, халтиргаа гулгааг хариуцна. 5.Шугам хоолойн ойр орчины цэвэрлэгээ, үйлчилгээг тогтмол хийнэ. 6.Төлөвлөгдөөгүй цаг үеийн ажлуудад оролцох. 7.Өөрийн буруугаас өмч хөрөнгө үрэгдүүлсэн, алдсан тохиолдолд учруулсан хохирлыг бүрэн төлнө. 8.Удирдлагаас өгсөн үүрэг даалгаварыг тухай бүр нь гүйцэтгэж, биелэлтийг танилцуулна. 9.Ажиллах хугацаандаа болсон зүйлийн талаар товч тодорхой тэмдэглэл хөтлөж, хариуцсан удирдлагадаа танилцуулна.	Боловсрол: Бүрэн бус дундаас дээш буюу бичиг үсгийн бүрэн боловсролтой байх. Мэргэжил: Мэргэжил харгалзахгүй. Туршлага: Жижүүр, харуул хамгаалалтын албанд 2-оос доошгүй жил ажилласан туршлагатай байх.
1	2	3	4	5	6	7	8	9	10	11

									<p>10.Байгууллагын ажлын онцлог, зайлшгүй шаардлагаар өөр төрлийн ажил үйлчилгээ хийх тохиолдолд хариуцсан удирдлагаас наряд авч гүйцэтгэнэ.</p> <p>11.Захиргаанаас зохион байгуулж байгаа олон нийтийг хамарсан ажилд идэвхитэй оролцоно.</p> <p>12.Байгууллагын дотоод журмыг мөрдөж, хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж ажиллана.</p> <p>13.Худаг № 4, 5, 7, 8-ын дотор болон гадна талбайд долоо хоногт 1 удаа их цэвэрлэгээ хийнэ.</p>	
Түлш дамжуулах цех	57	47	Түлш дамжуулах цехийн дарга	ИТА	1	1	Хүнд	<p>Түлш дамжуулах цехийн үйл ажиллагааны тасралтгүй, хэвийн найдвартай, аюул осолгүй ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, техник, зохион байгуулалтын бодлогыг боловсруулан хэрэгжүүлэх.</p>	<p>1. Түлш дамжуулах цехийн ажилтнуудыг удирдан зохион байгуулах.</p> <p>2. Түлш дамжуулах цехийн үндсэн болон туслах тоноглолын хэвийн найдвартай ажиллагааг бүрэн хангах, засвар, шинэчлэлтийн бодлого боловсруулж хэрэгжүүлэх.</p> <p>3. ХАБЭА-н тухай хууль, ТАД, ААД, ГАУСТ, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн норм стандарт, эрчим хүчний салбарт мөрдөгддөг хууль, тогтоомж, дүрэм, журам, зааврыг мөрдүүлэх, хяналт тавих, илэрсэн зөрчлийг арилгуулах.</p> <p>4. Түлш дамжуулах ТЭЗҮ-ийг дээшлүүлэх, арвилан хэмнэлт, үр ашгийг нэмэгдүүлэх бодлого боловсруулж хэрэгжүүлэх.</p>	<p>Боловсрол: Дээд боловсролын бакалавраас доошгүй зэрэгтэй байх. Мэргэжил: Дулааны инженер, цахилгааны инженер, уул уурхайн инженер, механик инженер</p> <p>Мэргэшил: Уул уурхай, эрчим хүчний салбарт 10-аас дээш жил ажилласан туршлагатай байх. Мэргэшсэн инженер байх.</p>
1	2	3	4	5	6	7	8	9	10	11

									5. Хариуцсан барилга, байгууламжийнхаа ашиглалт, засвар үйлчилгээг хариуцах. 6. Цехийн хүний нөөцийн бодлого боловсруулж, ажилтнуудыг сургах, дадлаажуулах, мэргэжил дээшлүүлэх, нөхөн хангалт хийх ажлыг удирдан зохион байгуулж, ээлжүүдийн тасралтгүй, хэвийн найдвартай ажиллагааг хангах.	Туршлага: Техник технологийн болон судалгаа, шинжилгээ арга зүйн онол, практикийн мэдлэгтэй, удирдан зохион байгуулах авьяас чадвартай байх.
	58		Түлш дамжуулах цехийн Ашиглалтын инженер	ИТА	1	5	Хүнд	Түлш дамжуулах цехийн ашиглалтын ажиллагааг тасралтгүй, найдвартай, хэвийн аюул осолгүй ажиллах нөхцлийг бүрдүүлэх, Монгол улсын хууль, тогтоомж, дүрэм журмын хэрэгжилтийг хангаж ажиллах.	1. Ашиглалтын инженер нь түлш дамжуулах цехийн үндсэн ба туслах тоноглолын бэлэн байдлыг хангаж, барилга байгууламжийн бүрэн бүтэн байдлыг хариуцна. 2. Техникийн ашиглалтыг сайжруулах, найдвартай ажиллагааг хангах, авари, саатал зөрчил гаргахгүй байх бодлого боловсруулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна. 3. Тоноглолын ажиллагааг ТАД-н дагуу барьж, ажилчидын аюулгүй ажиллагаанд хяналт тавих. 4. Ашиглалтын технологи ажиллагаанд судалгаа дүгнэлт хийж, цаашид хэрэгжүүлэх ажлын чиглэл бодлого боловсруулах. 5. Гарсан саатал, зөрчил, гэмтэл эвдрэлд судалгаа хийж, дүгнэлт гарган цаашид хийж хэрэгжүүлэх ажлын талаар цехийн даргад саналаа оруулах.	Боловсрол: Дээд боловсролын бакалавраас доошгүй зэрэгтэй байх. Мэргэжил: Дулаан, цахилгаан станцын инженер, Дулааны инженер. Мэргэшил: Станцад 7-оос доошгүй жил ажилласан байх. Туршлага: Техник технологийн болон судалгаа, шинжилгээ арга зүйн онол, практикийн мэдлэгтэй, удирдан зохион байгуулах авьяас чадвартай.
1	2	3	4	5	6	7	8	9	10	11

									<p>6. Тоноглолын ашиглалтын явцад шаардлагатай материал сэлбэгийн нормыг өөрчлөх, шинэчлэх ажлыг биечлэн хариуцах.</p> <p>7. Технологийн дагуу засварын ажил хийгдэж байгаад хяналт тавих.</p> <p>8. Ашиглалтын явцад гарсан аваари, саатал, гэмтэлийг бүртгэж акт бичих, гэм буруутай хүмүүст хариуцлага тооцох санал тодорхойлолтыг гаргах.</p> <p>9. Ашиглалтын явцад гарсан гэмтэл, сааталыг засварлах хүмүүст ажлын байр бэлдүүлж наряд, ам шийдвэр өгч аюулгүй хийж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах.</p> <p>10. Засварт хүлээлгэн өгөх, засвараас хүлээн авах ажлыг биечлэн зохион байгуулах.</p> <p>11. Цехийн хэмжээнд галын аюулгүй байдлыг биечлэн бүрэн хариуцаж ажиллах.</p> <p>12. Цехийн ТЭЗҮ-нд шинжилгээ хийж, түүнийг дээшлүүлэх нөхцөлийг бүрдүүлэх.</p>	
	59		Түлш дамжуулах цехийн Ээлжийн дарга буюу удирдах шитний машинч	Техникийн ажилтан	4		Хүнд	Түлш дамжлагын хэвийн найдвартай, үр ашигтай тасралтгүй ажиллагааг хангах үүднээс, түлш дамжлагын ажиллагааг найдвартай тасралтгүй явуулах.	<p>1. Хөдөлмөр хамгааллын хувцас, гутал, каск, хувийн хамгаалах хэрэгслийг тогтмол, аюулгүй ажиллагааны дүрэмд заасны дагуу хэрэглэнэ. Аюулгүй ажиллагааны дүрмийн заалтыг гажуудуулж хэрэглэхийг хориглоно.</p> <p>2. Хуваарьт ажлын байрны эд аж ахуйг хариуцан ажиллана.</p>	Боловсрол: Дээд боловсролын бакалавраас доошгүй зэрэгтэй байх. Мэргэжил хамаарахгүй.
1	2	3	4	5	6	7	8	9	10	11

									<p>3. Хариуцсан тоног төхөөрөмжийн найдвартай бэлэн байдлыг хариуцан ажиллана.</p> <p>4. Ажлын байраа дур мэдэн орхин явахыг хориглоно. Ажлын байрыг зайлшгүй орхиж явах шаардлага гарвал цехийн дарга ашиглалтын инженерт мэдэгдэн зөвшөөрөл авсан байна.</p> <p>5. Хүний амь насанд аюултай нөхцөлд удирдлагын зөвшөөрөлгүй ажлын байрыг орхиж болно.</p> <p>6. Цехийн удирдлага болон ашиглалт засварын инженерээс өгсөн шийдвэрийг тэр даруйд нь зөв биелүүлж хариу мэдэгдэнэ.</p> <p>7. Хариуцсан ажлын байрны агаар дахь тоосны хэмжээг тэсрэлт, дэлбэрэлтийн аюулгүйн ба эрүүл ахуйн шаардлагын дагуу байлгах болон гадагш хаяж байгаа агаар дахь тоосны хэмжээг нормоос үл хэтрүүлэх шаардлагыг хангуулахад анхаарч тоос сорох болон намжаах төхөөрөмжүүдийн хэвийн найдвартай ажиллагааг шалгаж, илэрсэн гэмтэл доголдлын талаар засвар ашиглалтын инженерт мэдээлж засварлуулах арга хэмжээг авахуулна.</p> <p>8. Тухайн хариуцсан ажлын байрандаа засварын ажлын байр бэлтгэгчийн үүргийг гүйцэтгэх бөгөөд хийгдэж байгаа засварын ажилд хяналт тавьж ажиллана.</p>	<p>Мэргэшил: Мэргэшлийн бэлтгэлд хамрагдаж шалгалт өгч тэнцсэн. Эрчим хүчний сургалт үйлдвэрлэлийн төвийн машинчийн сургалтанд хамрагдсан байх.</p>
1	2	3	4	5	6	7	8	9	10	11

									<p>9. Ээлж солилцох үед ажлын байраа хүлээн авах болон хүлээлгэн өгөх үйл ажиллагааг заавал ажлын байранд гүйцэтгэнэ. Ээлжээ хүлээлгэн өгөлгүй ээлжнээс буухыг хориглоно.</p> <p>10. Ажил гүйцэтгэхдээ ТАД, ААД, Төмөр замын техник ашиглалтын дүрэм, галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж ажиллана.</p> <p>11. Хариуцсан тоноглолын цахилгаан хөдөлгүүрийн хүчдэл унасан бол заавал цахилгааны ээлжийн монтероор хөндийрүүлгийн эсэргүүцлийг шалгуулах буюу шалтгааныг олоогүй үед дахин залгахыг хориглоно.</p>	
	60		Вагон хөмрөгчийн машинч	V	4	40	Хүнд	Вагон хөмрөгчийн тоног төхөөрөмж, туслах тоноглолын хэвийн, тасралтгүй ажиллагааг хангах,	Вагон хөмрөх төхөөрөмжөөр нүүрс буулгаж, зуухнуудыг нүүрсээр тасралтгүй хангаж нөөцлөх, вагон хөмрөгчийн ашиглалтын үед үндсэн болон туслах тоноглолын бүрэн бүтэн байдал хэвийн, тасралтгүй найдвартай ажиллагаанд хяналт тавьж, ажлын байр болон тоног төхөөрөмжид гарч болзошгүй гэмтлээс урьдчилан сэргийлж эргэлт, үзлэг шалгалт цэвэрлэгээг тогтмол хийж ажиллана. Вагоноос нүүрс буулгах, вагон цэвэрлэх, вагон хөмрөгчийн тоноглол болох хөмрөх төхөөрөмж, вагоны дугуй хавчигч, ачаатай вагон чирэгч, хоосон вагон түлхэгч, хоосон вагон шилжүүлэгч,	Бүрэн дунд ба түүнээс дээш боловсролтой, тоноглолын гэмтлийг илрүүлэх чадвартай, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг зөвөөр хүлээж авах, хамт олонтой зүй зохистой харьцах, багаар ажиллах чадвартай, галын хэрэгсэл ашиглах чадварыг эзэмшсэн, III зэргийн дамжлагын машинчийн ажил үүргийг гүйцэтгэх чадвартай, хараа, сонсгол, амьсгалын
	61			IV	4		Хүнд			
1	2	3	4	5	6	7	8	9	10	11

									туузан тэжээгчийг ажилд залгах, зогсоох, турших ажлыг вагон хөмрөгчийн машинчийн V зэргийн машинчийн хяналтын дор гүйцэтгэх, тоноглолыг засварт өгөх, төхөөрөмжийг засвараас ажилд хүлээн авахад оролцох, тоноглолд гарсан гэмтлийг илрүүлэх, вагон хөмрөх төхөөрөмжид гарсан аварийг устгах, илчит тэрэг болон вагон чирэгчээс авто угсрааг салгах ажлыг бие даан хийж гүйцэтгэнэ.	замын болон зүрх судасны архаг үрэвсэл, харшилгүй, эрүүл чийрэг, сэтгэцийн ямар нэгэн өөрчлөлтгүй байх.
	62		Нуруулдан овоолох төхөөрөмжийн машинч буюу түлш буулгах төхөөрөмжийн машинч	V	4		Хүнд	Нүүрс нуруулдан овоолох төхөөрөмжийн тоноглолын хэвийн найдвартай, үр ашигтай тасралтгүй ажиллагааг хангах	Станцад ирж байгаа вагон хөмрөгчөөр буулгасан нүүрсийг нуруулдан овоолох төхөөрөмжийг ашиглан талбайд буулгаж нөөцлөх, нүүрсний агуулахаас нуруулдан овоолох төхөөрөмжийг ашиглан зуухыг нүүрсээр тасралтгүй хангах, нуруулдан овоолох тоног төхөөрөмжийн тоноглолын хэвийн, найдвартай, үр ашигтай, тасралтгүй ажиллагааг хангах, ашиглалтын үеийн ажиллагаанд хяналт тавьж, ажлын байр болон тоног төхөөрөмжид гарч болзошгүй гэмтлээс урьдчилан сэргийлж эргэлт, үзлэг шалгалт цэвэрлэгээг тогтмол хийж, тоноглолоо явуулах ба зогсоох, бага хэмжээний гэмтлийг устгана.	Бүрэн дунд буюу түүнээс дээш боловсролтой, өргөх, зөөх механизмын эрхтэй, тоноглолын гэмтлийг илрүүлэх чадвартай, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг зөвөөр хүлээж авах хамт олонтой зүй зохистой харьцах, удирдан ажиллах болон багаар ажиллах чадвартай, галын унтраах багаж хэрэгсэл ашиглах чадварыг эзэмшсэн, гарч буй өөрчлөлтөнд зохицон ажиллах чадвартай, V зэргийн түлш дамжуулахын машинчийн ажил үүргийг гүйцэтгэх чадвартай,
1	2	3	4	5	6	7	8	9	10	11

										Түлш дамжуулахын машинчаар 2-оос дээш жил ажилласан туршлагатай байх, хараа, сонсгол, амьсгалын замын болон зүрх судасны архаг үрэвсэл, харшилгүй, эрүүл чийрэг, сэтгэцийн ямар нэгэн өөрчлөлтгүй байх.
	63		Түлш дамжуулахын машинч	IV	28		Хүнд	Түлш дамжлагын хэвийн найдвартай, үр ашигтай тасралтгүй ажиллагааг хангах үүднээс, түлш дамжлагын ажиллагааг найдвартай тасралтгүй явуулах.	Технологийн схемийн дагуу зуухыг нүүрсээр тасралтгүй хангах. вагоноос нүүрсийг буулгаж, чанарыг алдагдуулахгүй талбайд нөөцлөхийн зэрэгцээ тоноглолыг залгах, зогсоох, хэвийн, тасралтгүй найдвартай ажиллагааг хангаж ажиллах, тоноглолыг засварт өгөх, засварлагдсан тоног төхөөрөмжийг ажилд хүлээн авахад оролцох, ажлын байр болон тоног төхөөрөмжид эргэлт, үзлэг шалгалт, тосолгоо, үйлчилгээ, цэвэрлэгээг тогтмол хийж, гарч болзошгүй гэмтлээс урьдчилан сэргийлж гарсан гэмтэл, аваари саатлыг эрт илрүүлэх, устгах ажлыг ХАБЭА, ТАД, ААД, ГАУСД-ийн дагуу гүйцэтгэнэ.	Бүрэн бус дунд ба түүнээс дээш боловсролтой, тоноглолын гэмтлийг илрүүлэх чадвартай, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг хүлээж авах хамт олонтой зүй зохистой харьцах, багаар ажиллах чадвартай, гарч буй өөрчлөлтөнд зохицон ажиллах чадвартай, вагон хөмрөх машинчийн III зэргийн машинчийн ажил үүрэг гүйцэтгэх чадвар эзэмшсэн, хараа, сонсгол, амьсгалын замын болон зүрх судасны архаг үрэвсэл, харшилгүй, эрүүл чийрэг, сэтгэцийн ямар нэгэн өөрчлөлтгүй байх.
1	2	3	4	5	6	7	8	9	10	11

	64		Үйлдвэрийн цэвэрлэгээ үйлчилгээний ажилтан	Үйлчилгээний ажилтан	1	1	Хүнд	Хариуцсан талбайн цэвэрлэгээг тогтмол хийж, ажиллагсдыг эрүүл орчинд ажиллах нөхцөл боломжоор хангах.	<p>1.Хуваарьт талбайд батлагдсан хувиарын дагуу цэвэрлэгээг өдөр бүр чанарын өндөр түвшинд цэвэрлэх.</p> <p>2.Зуухан цехийн эрэгтэй, эмэгтэй бие засах өрөөний цэвэрлэгээг өдөр бүр хийж, гүйцэтгэх.</p> <p>Хуваарьт талбайн тохижилт соёлжилт, эд хөрөнгийг шууд хариуцах.</p> <p>3.Байгууллагаас тавьж олгосон хувин, шүүр, шалны мод, арчих материал, цэвэрлэгээний болон ариутгах бодис зэргийг нормын дагуу хэрэглэх.</p> <p>4.Цэвэрлэгээ үйлчилгээндээ дэвшилттэй арга хэлбэрийг аль болохоор нэвтрүүлж, үйлчилгээний соёлч, чанарыг эрхэмлэн ажиллах.</p>	<p>Боловсрол: Бага буюу түүнээс дээш буюу бичиг үсгийн бүрэн боловсролтой байх.</p> <p>Мэргэжил: Мэргэжил харгалзахгүй.</p> <p>Мэргэшил: Шаардахгүй</p>
Цахилгаан цех	65	4	Цахилгаан цехийн дарга	ИТА	1	1	Хүнд	Технологи удирдлагын системийн инженерүүд, ДХХА-н хэсэг, Цахилгааны хэсэг, Реле хамгаалалт автоматикийн хэсгүүдийн үйл ажиллагааг тасралтгүй, хэвийн найдвартай, аюул осолгүй ажиллах нөхцлийг бүрдүүлж, тэдгээрийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, техник зохион байгуулалтын бодлогыг боловсруулан хэрэгжүүлэх, Монгол улсын хууль, тогтоомж, дүрэм журам, зааврын хэрэгжилтийг хангуулахад оршино.	<p>1. Технологи удирдлагын системийн программист инженер, ажилтнууд, ДХХА-н хэсэг, Цахилгааны хэсэг, Реле хамгаалалт автоматикийн хэсгүүдийн ажилтнуудыг удирдан зохион байгуулж, ажил үүргийг хуваарилах.</p> <p>2. Технологи удирдлагын системүүд, ДХХА-н хэсэг, Цахилгааны хэсэг, Реле хамгаалалт автоматикийн хэсгүүдийн үндсэн болон туслах тоноглолын хэвийн найдвартай ажиллагааг бүрэн хангах, бүрэн бүтэн байдлыг хариуцах, засвар, шинэчлэлтийн бодлого боловсруулж хэрэгжүүлэх.</p>	<p>Боловсрол: Дээд боловсролын бакалавараас доошгүй зэрэгтэй байх.</p> <p>Мэргэжил: ДХХА, Цахилгаан, Дулааны инженер</p> <p>Мэргэшил: Эрчим хүчний салбарт 5-аас доошгүй жил ажилласан байх.</p> <p>Туршлага: Техник технологийн болон судалгаа, шинжилгээ арга зүйн онол, практикийн мэдлэгтэй, удирдан зохион байгуулах авьяас чадвартай байх.</p>
1	2	3	4	5	6	7	8	9	10	11

									<p>3. ХАБЭА-н тухай хууль, ААД, ТАД, ГАУСД, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн норм стандартыг мөрдүүлэх хяналт тавих, илэрсэн зөрчлийг арилгуулах.</p> <p>4. ДХХА-н хэсэг, Цахилгааны хэсэг, Реле хамгаалалт автоматикийн хэсэг, ТУСП-ын ТЭЗҮ-г дээшлүүлэх, арвилан хэмнэлт, үр ашгийг нэмэгдүүлэх бодлого боловсруулж, хэрэгжүүлэх.</p> <p>5. Хариуцсан барилга, байгууламжийнхаа ашиглалт, засвар үйлчилгээг хариуцах.</p>	
	66		Технологи удирдлагын системийн Ахлах инженер	ИТА	1	1	Хүнд	<p>1. Дулааны станцын үйлдвэрлэлийн удирдлагын системийн /DCS- Distributed control system/, ажилтнуудын компьютерын программ хангамж, станцад суурьлуулсан камер, бичих төхөөрөмж, ERP программын хэвийн найдвартай ажиллагааг хангаж, түүнд өөрчлөлт оруулах, тохиргоо, хамгаалалт хийх.</p> <p>2. Компанийн цахим флатформуудын ашиглалт, хөгжүүлэлт, зарлан мэдээллүүдийг хийх.</p>	<p>1. Компанийн мэдээлэл технологийн үйл ажиллагааг зохион байгуулж, хариуцаж хяналт тавьж зохион байгуулах.</p> <p>2. Удирдлагын систем, ажилтнуудын компьютерын программ хангамж, станцад суурьлуулсан камер, бичих төхөөрөмж, ERP программын хэвийн найдвартай ажиллагааг хангаж, шаардлагатай үед засвар, өөрчлөлт хийх ажлыг зохион байгуулах.</p> <p>3. Системүүдийн хориг хамгаалалтыг зөв дарааллаар, найдвартай ажиллаж байгааг тогтмол шалгах ажлыг зохион байгуулах.</p> <p>4. Системүүдийн автомат горим хэвийн найдвартай ажиллаж байгаад байнга хяналт тавьж ажиллах.</p>	<p>Боловсрол: Дээд боловсролтой бакалавраас доошгүй зэрэгтэй байх.</p> <p>Мэргэжил: Программ хангамж, программ зохиох, боловсруулах, хөгжүүлэх чиглэлээр их дээд сургууль төгсөж мэргэжил эзэмшсэн байх.</p> <p>Мэргэшил: Эрчим хүчний салбарт тухайн мэргэжлээрээ 2-оос доошгүй жил ажилласан байх.</p>
1	2	3	4	5	6	7	8	9	10	11

									<p>5. Амгалан дулааны станцад суурьлагдсан контроллёр, модулуудын хэвийн ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, зохион байгуулалтыг хийх.</p> <p>6. Монгол улсын хөдөлмөрийн тухай хууль, Техник ашиглалтын дүрэм, Аюулгүй ажиллагааны дүрэм, Хөдөлмөрийн гэрээ, Хөдөлмөрийн дотоод журам бусад холбгдох хууль, тогтоомж, дүрэм журам, заавруудыг мөрдөж ажиллах.</p> <p>7. Компанийн цахим флатформуудын ашиглалт, хөгжүүлэлт, зарлан мэдээллүүдийг хариуцах ба вебсайт, телеграмм, фэйсбүүк пэйж, ажилтнуудын албаны цахим шуудан, юүтүб суваг зэрэгт ажил хэргийн холбоотой зарлан мэдээллүүдийг тухай бүр байршуулах ажлыг зохион байгуулж, хяналт тавих.</p> <p>8. ТУСПИ инженерүүдийн ажил үүргийг зохион байгуулж, тэдгээрийн ажилд хяналт тавих.</p>	
	67		Технологи удирдлагын системийн програмист инженер	ИТА	2	2	Хүнд	<p>Дулааны станцын үйлдвэрлэлийн удирдлагын системийн /DCS- Distributed control system/, ажилтнуудын компьютерын программ хангамж, станцад суурьлуулсан камер, бичих төхөөрөмж, ERP программын хэвийн найдвартай ажиллагааг хангаж, түүнд өөрчлөлт оруулах, тохиргоо, хамгаалалт хийх.</p>	<p>1. Компанийн мэдээлэл технологийн үйл ажиллагааг хариуцаж хийх.</p> <p>2. Удирдлагын систем, ажилтнуудын компьютерын программ хангамж, станцад суурьлуулсан камер, бичих төхөөрөмж, ERP программын хэвийн найдвартай ажиллагааг хангаж, шаардлагатай үед засвар, өөрчлөлт хийх.</p>	<p>Боловсрол: Дээд боловсролтой бакалавраас доошгүй зэрэгтэй байх.</p> <p>Мэргэжил: Программ хангамж, программ зохиох, боловсруулах, хөгжүүлэх чиглэлээр их дээд сургууль төгсөж мэргэжил</p>
1	2	3	4	5	6	7	8	9	10	11

									<p>3. Системүүдийн хориг хамгаалалтыг зөв дарааллаар, найдвартай ажиллаж байгааг тогтмол шалгаж байх.</p> <p>4. Системүүдийн автомат горим хэвийн найдвартай ажиллаж байгаад байнга хяналт тавьж ажиллах.</p> <p>5. Амгалан дулааны станцад суурьлагдсан контроллёр, модулуудын хэвийн ажиллах нөхцөлийг бүрдүүлж ажиллах.</p> <p>6. Монгол улсын хөдөлмөрийн тухай хууль, Техник ашиглалтын дүрэм, Аюулгүй ажиллагааны дүрэм, Хөдөлмөрийн гэрээ, Хөдөлмөрийн дотоод журам бусад холбогдох хууль, тогтоомж, дүрэм журам, заавруудыг мөрдөж ажиллах.</p> <p>7. Компанийн цахим флатформуудын ашиглалт, хөгжүүлэлт, зарлан мэдээллүүдийг хариуцах ба вебсайт, телеграмм, фэйсбүүк пэйж, ажилтнуудын албаны цахим шуудан, ютүб суваг зэрэгт ажил хэргийн холбоотой зарлан мэдээллүүдийг тухай бүр байршуулах.</p>	<p>эзэмшсэн байх. Мэргэшил: Эрчим хүчний салбарт тухайн мэргэжлээрээ 2-оос доошгүй жил ажилласан байх.</p>
Цахилгаан цех-Цахилгааны хэсэг	68	12	Цахилгааны инженер	ИТА	1	1	Хүнд	<p>Эрчим хүчний дулаан үйлдвэрлэхэд цахилгаан хангамжийн найдвартай ажиллагааг хангах, станцын үр ашгийг дээшлүүлэх хүрээнд цахилгаан тоноглолын судалгаа, шинжилгээ хийх.</p>	<p>1. Дулааны эрчим хүчийг хэвийн найдвартай, тасралтгүй үйлдвэрлэхэд цахилгаан хангамжийн найдвартай ажиллагааг хангах.</p> <p>2. Цахилгаан тоноглолын найдвартай ажиллагааны горимын тооцоо, судалгаа хийх.</p>	<p>Боловсрол: Дээд боловсролын бакалавраас доошгүй зэрэгтэй байх. Мэргэжил: Цахилгаан хангамжийн инженер, Цахилгааны</p>
1	2	3	4	5	6	7	8	9	10	11

									<p>3. Станц дахь цахилгаан тоног төхөөрөмж, технологийг боловсронгуй болгох, шинэчлэх талаар судалгаа, бодлого боловсруулах.</p> <p>4. Станц дахь цахилгаан тоног төхөөрөмжийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, техникийн шийдэл гаргах.</p> <p>5. Цахилгаан байгууламжид мөрдөх аюулгүй ажиллагааны дүрэм, ХАБЭА-н тухай хууль, ААД, ТАД-ийн заалтыг мөрдөх, хариуцсан ажилтнуудаараа мөрдүүлэх, осол, зөрчил гаргахгүй ажиллах.</p> <p>6. Ажлын байранд ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийг шаардлагын хэмжээнд тогтмол хэрэглэх, ажилтнууддаа тогтмол хэрэглэж хэвшүүлэх.</p> <p>7. ХХБ, цахилгаан хөдөлгүүр, тоноглолын тэжээлийн кабелийн хэвийн найдвартай ажиллагааг хангах.</p>	инженер Мэргэшил: Цахилгааны инженер Туршлага : Эрчим хүчний салбарт мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан байх
	69		Цахилгаанчин	V	4	11	Хүнд	Дулааны эрчим хүч үйлдвэрлэх, түгээхэд цахилгаан хангамжийн найдвартай, тасралтгүй ажиллагааг хангах.	Ээлжийн хугацаанд дулааны станцын цахилгаан тоног төхөөрөмж, гэрэлтүүлэг кабелийн аж ахуйн ба хуваарилах байгууламж, зуух болон дулааны тоног төхөөрөмжийн технологийн дохиолол ба хамгаалалт, бусад цахилгаан тоноглолд гарсан гэмтлийг хурдан шуурхай устгаж, цахилгаан, дулааны тоноглолын хэвийн ажиллагааг хангаж ажиллана. 1000В хүртэлх хүчдлийн дотоод хэрэгцээний цахилгаан тоноглолд шуурхай сэлгэн	Бүрэн дунд ба түүнээс дээш боловсролтой, Эрчим хүчний хөгжлийн төв, ЭХСТөвд цахилгааны чиглэлээр суралцаж төгссөн байх цахилгааны аюулгүй ажиллагааны эрх олгох сургалтад хамрагдаж цахилгааны аюулгүй ажиллагааны III зэргийн группын
	70			IV	7		Хүнд			
1	2	3	4	5	6	7	8	9	10	11

									залгалтыг ААД, ТАД, ГАУСД-ын дагуу хийх, гэмтэл илрүүлэх, тодорхойлох, гарсан аваарийг устгахад оролцох, хоёрдогч хэлхээний бага хэмжээний богино хугацаанд устгах гэмтлийг арилгах, цахилгааны хуваарилах байгууламжууд болон цахилгаан тоног төхөөрөмжүүдэд эргэлт шалгалт хийж, илэрсэн зөрчлийг шууд удирдлагад мэдэгдэж холбогдох ажилтаны хамт хэвийн болгож, тоноглолын хэвийн найдвартай ажиллагааг хангаж ажиллана.	үнэмлэхжсэн, цахилгааны аюулгүй ажиллагаа, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөв дадал эзэмшсэн, хараа, сонсгол, амьсгалын замын болон зүрх судасны архаг үрэвсэл, харшилгүй, эрүүл чийрэг, сэтгэцийн ямар нэгэн өөрчлөлтгүй байх
Цахилгаан цех-Реле хамгаалалт автоматикийн хэсэг	71	3	Реле хамгаалалт, автоматикийн инженер	ИТА	1	1	Хүнд	Амгалан дулааны станцын II хэлхээний цахилгаан тоног төхөөрөмжийн хэвийн найдвартай ажиллагааг хангах.	1. Амгалан дулааны станцын II хэлхээний цахилгаан тоног төхөөрөмжийн хэвийн найдвартай ажиллагааг хангах, ажиллагаанд нь хяналт тавих, 2. Реле хамгаалалтын тоноглолын ажиллагаанд хяналт тавьж ашиглалтын судалгаа мэдээ материал бүрдүүлж, хэвийн ажиллагааг хангаж ажиллах. 3. Техникийн болон технологийн зөрчлийг судлан бүртгэх комисст оролцон дүгнэлт өгөх. 4. Тоноглолын их болон урсгал засвар, хөрөнгө оруулалт өөрчлөлт шинэчлэлтийн ажлыг төлөвлөх, засварын ажлын гүйцэтгэл, мэдээ, тайланг гаргах. 5. Станцын бүх хүчдэлийн тоноглол ЦДКШ-ын РХ-ын бүх тавил тооцоог хийж, РХ-ын үндсэн шаардлагыг хангуулж	Боловсрол: Дээд боловсролын бакалавр ба түүнээс дээш зэрэгтэй Мэргэжил: Цахилгаан системийн автоматжуулалтын инженер Мэргэшил: Эрчим хүчний салбарт 3-оос доошгүй жил ажилласан байх. Аюулгүй ажиллагааны дүрмийн групптэй байх.
1	2	3	4	5	6	7	8	9	10	11

									<p>ажиллуулах. Цахилгаан байгууламжид мөрдөх аюулгүй ажиллагааны дүрэм, ХАБЭА-н тухай хууль, ААД, ТАД-ийн заалтыг мөрдөх, хариуцсан ажилтнуудаараа мөрдүүлэх, осол, зөрчил гаргахгүй ажиллах.</p> <p>6. Ажлын байранд ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийг шаардлагын хэмжээнд тогтмол хэрэглэх, ажилтнууддаа тогтмол хэрэглэж хэвшүүлэх.</p> <p>7. Станц дахь РХА тоног төхөөрөмжийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, техникийн шийдэл гаргах.</p> <p>8. Долоо хоног, сар, улирал, жилийн мэдээ төлөвлөгөө тайлангуудыг нэгтгэн гаргаж өгөх. Реле хамгаалалт автоматикын техникчийн ажлыг зохион байгуулж үүрэг даалгавар өгч, ажилд нь хяналт тавьж, гүйцэтгэлийг нь шалгаж байх.</p> <p>9. Реле хамгаалалт автоматикын техникчийн өдөр тутмын ажлыг хуваарилан ажилтай нь холбогдсон зааварчилгааг өгч, тэднийг мэргэжил арга зүйгээр удирдаж ажиллах.</p> <p>10. Реле хамгаалалт автоматикын техникчийн мэдлэг мэргэжлийг дээшлүүлэх талаар сургалтыг зохион байгуулж ажиллах.</p> <p>11. РХА-ын тоног төхөөрөмжид хийх техникийн үзлэг үйлчилгээг графикийн дагуу тогтмол хийж гүйцэтгүүлэх.</p>	
1	2	3	4	5	6	7	8	9	10	11

									12. Хэрэглэгдэж байгаа материал сэлбэгийн норм, хэмжээ зарцуулалтад хяналт тавьж зардлыг багасгах талаар санаачлагатай ажиллах. 13. Өөрийн хариуцсан өмч хөрөнгө, эд материалын хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж бүрэн бүтэн байдлыг хариуцах.	
	72		Цахилгааны реле хамгаалалтын техникч	Техникийн ажилтан	2	2	Хүнд	Амгалан дулааны станцын II хэлхээний цахилгаан тоног төхөөрөмжийн хэвийн найдвартай ажиллагааг хангах.	Хоёрдогч хэлхээг, гүйдлийн трансформатор, таслуурын автомат, реле зэргийг задлах угсрах, шалгах, тохируулах, хоёрдогч хэлхээний маркировка хийх, гүйдэл, хүчдлийн трансформаторын туршилтын хэлхээ цуглуулах, хоёрдогч хэлхээнд гал хамгаалагч сонгон авах, текстолит хув, албоцемент, гетинакс гэх мэт хөндийрүүлэгчийн материалыг зургийн дагуу бэлтгэх, хамгаалалтын панелийг бэхлэх, байрлуулах, кабелийн гэмтэл арилгах, халуун гагнуур хийх, хөндийрүүлэгч сэргээх, эд ангийн зураг бүдүүвч (загвар) гаргах ба түүний дагуу ажил гүйцэтгэх, реле засварын ороомог ороох тогтмол гүйдлийн хэлхээний газардлага арилгах. Контакт, пускатель, удирдлагын бүх төрлийн түлхүүрийг засах тохируулах. Батлагдсан графикийн дагуу цэвэрлэгээ үйлчилгээ болон чангалгаа хийнэ.	
1	2	3	4	5	6	7	8	9	10	11

Цахилгаан цех- Дулааны хянах хэмжүүр автоматикийн хэсэг	73	10	Дулааны хянах хэмжүүр автоматикийн инженер	ИТА	1	1	Хүнд	Дулаан үйлдвэрлэлийн процессын үндсэн болон туслах тоноглолуудын ажиллагааны байдал, дулаан процессын хяналт, хэмжилтэнд ашиглагдах хянах, хэмжих хэрэгслүүдийн хэвийн найдвартай ажиллагааг хангах, тэдгээрийн үзлэг, үйлчилгээ, засвар, тохируулгын ажлыг хийж гүйцэтгэх	1. Станцын тоног төхөөрөмжүүд /зуух тэдгээрийн туслах тоноглолууд/ дулааны процессын нэгдсэн удирдлагын систем /DCS –distributed control system /-ийн тогтвортой, найдвартай ажиллагааг хангах. 2. Дулааны хянах хэмжүүрүүдэд шалгалт тохируулга хийхэд баталгаажуулах. 3. Хэмжилтийн үйл ажиллагаанд батлагдсан "Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах" хууль, аргачлал, стандартуудыг мөрдөх. 4. Дулааны хянах хэмжүүр автоматикийн засварчидад зөвлөмж заавар, зааварчилгаа өгөх. 5. Монгол улсын хөдөлмөрийн тухай хууль, ХАБЭА-н дүрэм, Техник ашиглалтын дүрэм, Аюулгүй ажиллагааны дүрэм мөрдөж ажиллах	Боловсрол: Дээд боловсролын бакалавраас доошгүй зэрэгтэй байх. Мэргэжил: Дулааны процессын автоматжуулалтын инженер Мэргэшил: Станцад 5-аас дээш жил ажилласан байх. Туршлага: ДЦС болон Дулааны станц, дулааны сүлжээ, зэрэг байгууллагуудад ажиллаж байсан дадлага туршлагатай байх.
	74		Дулааны хянах хэмжүүр автоматикийн засварчин	V	5	9	Хүнд	Дулаан үйлдвэрлэлийн процесст оролцдог үндсэн болон туслах тоноглолуудын ажиллагааны байдал, дулаан процессийн хяналт, хэмжилтэнд ашиглагдах Хянах, хэмжих хэрэгслүүдийн хэвийн найдвартай ажиллагааг хангах, тэдгээрт үзлэг, засвар, үйлчилгээ, тохируулгын ажлыг гардан гүйцэтгэнэ.	Эрчим хүчний инженерийн бакалавраас доошгүй зэрэгтэй, тооцоо судалгаа, дүн шинжилгээ хийж үнэлэлт гаргах, орчин үеийн техник хэрэгслийг ажлын байранд сайн ашиглах, харилцааны ур чадвартай, гарч буй өөрчлөлтөнд зохицон ажиллах чадвартай байх, хөдөлмөрийн	
	75			IV	4		Хүнд			
1	2	3	4	5	6	7	8	9	10	11

										аюулгүй байдал, эрүүл ахуйн зөв дадал эзэмшсэн, дулаан даралтын шалгалт тохируулгын эрхтэй, зураг схем унших чадвартай байх.
Засварын цех	76	23	Засварын цехийн дарга	ИТА	1	1	Хүнд	Станцын найдвартай ажиллагааг хангахын тулд станцын үндсэн ба туслах тоноглолын их, урсгал засварыг графикийн дагуу төсөвт өртөгт нь багтаан чанартай хийж гүйцэтгүүлэх, графикт бус засвар үйлчилгээ, гэмтэл доголдол засварын бусад ажлыг түргэн шуурхай гүйцэтгэж, станцын хэвийн найдвартай, аюулгүй ажиллагааг бүрэн хангах.	1.Тоноглолын засварын ажиллагааг удирдан зохион байгуулах, хяналт тавих, зөвлөх. 2.Бэлтгэлд байгаа тоноглолуудын бэлэн байдалд тогтмол хяналт тавих. 3.Тоноглолуудад гарсан гэмтэл доголдлыг түргэн шуурхай арилгаж найдвартай ажиллагааг хангах, бэлтгэлд оруулах. 4.Станцын тоноглолуудыг графикт хугацаанд нь багтаан их, урсгал засварыг чанартай хийж гүйцэтгүүлэх.	Боловсрол: Дээд боловсролын бакалавраас доошгүй зэрэгтэй байх. Мэргэжил: Дулааны цахилгаан станцын инженер, Дулааны инженер Мэргэшил: Эрчим хүчний салбарт 7-оос дээш жил ажилласан, салбарын үйл ажиллагааны онцлогийг мэддэг байх. Туршлага : Техник технологийн болон судалгаа, шинжилгээ арга зүйн онол, практикийн мэдлэгтэй, удирдан зохион байгуулах авьяас чадвартай байх.
	77		Станцын тоног төхөөрөмжийн засварын инженер	ИТА	4	5	Хүнд	Станцын найдвартай ажиллагааг хангахын тулд үндсэн ба туслах тоноглолын их, дунд, урсгал засварыг графикийн дагуу төсөвт өртөгт нь багтаан хугацаанд нь чанартай хийж гүйцэтгэх,	1.Засварын ажлын төлөвлөгөө, ажлын эзэлхүүн, графикийг гаргаж, хянуулан, батлуулах. 2.Засварын ажлыг удирдан зохион байгуулах, хяналт тавих, төсвийн дагуу хугацаанд нь чанартай гүйцэтгэх, актаар хүлээлгэн өгөх	Боловсрол: Дээд боловсролын бакалавраас доошгүй зэрэгтэй байх. Мэргэжил: Дулааны цахилгаан станцын инженер, Дулааны
1	2	3	4	5	6	7	8	9	10	11

								графикт бус засвар үйлчилгээ, гэмтэл доголдол засварын бусад ажлыг түргэн шуурхай гүйцэтгэж, станцын хэвийн найдвартай, аюулгүй ажиллагааг бүрэн хангах.	<p>3.Шугам хоолой, хаалт арматурт гарсан гэмтэл саатлыг түргэн шуурхай устгах арга хэмжээг авах, найдвартай хэвийн ажиллагааг хангах.</p> <p>4.Шугам хоолой, хаалт арматурт тогтмол үзлэг хийж, хяналт тавьж, дүгнэлт гаргаж, шууд удирдлагадаа танилцуулах.</p> <p>5.Засварын материалын тайлан, тооцоог тухай бүр нь гаргах, материал сэлбэгийн зарцуулалтад хяналт тавих, тооцоо гаргах.</p> <p>6.Тоног төхөөрөмжийн паспорт, бүртгэл, засварын акт, формуляр, баримт бичигийг тухай бүр хөтлөх.</p> <p>7.Засварт шаардлагатай материал сэлбэгийн захиалгын жагсаалт гаргаж, хугацаанд нь нийлүүлэх талаар хангамжийн ажилтнуудаас шаардах.</p> <p>8.Тоноглолын ашиглалтын түвшинд улирал бүр дүгнэлт өгч, түүнийг сайжруулах ажлыг зохион байгуулах.</p> <p>9.Техникийн шат дамжлагыг шинэчлэн, өөрчлөх шинэ бодлого оновчтой саналын талаар зураг төсөв гаргаж Техникийн комиссоор хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх.</p> <p>10.Гүний худаг, гадна шугам сүлжээ, ус зөөлрүүлэх төхөөрөмж, усны бак, дизель түлш, нарийн үнс, хийн бакнууд, үйлдвэрийн барилга, байгууламжуудын сантехникийн шугамын хэвийн</p>	<p>Дулааны инженер, Механик инженер Мэргэшил: Эрчим хүчний салбарт 7-оос дээш жил ажилласан, салбарын үйл ажиллагааны онцлогийг мэддэг байх.</p> <p>Туршлага: Техник технологийн болон судалгаа, шинжилгээ арга зүйн онол, практикийн мэдлэгтэй, удирдан зохион байгуулах авьяас чадвартай байх.</p>
1	2	3	4	5	6	7	8	9	10	11

									найдвартай ажиллагааг хангах, тэдгээрийн засварын ажлыг гүйцэтгэх, хүлээлгэн өгөх.	
	78		Барилга, сантехник, дулаан хангамжийн инженер	ИТА	1		Хүнд	Монгол Улсын барилгын тухай хууль, хот суурин усан хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль, Эрчим хүчний тухай хууль, бусад холбогдох хууль, тогтоомж, стандарт норм, дүрмийн дагуу компанийн барилга, байгууламж, дулаан, сантехник, усан хангамжийн шугам хоолой, хэрэгслийн ашиглалт, засвар, үйлчилгээг хариуцан зохион байгуулах.	<p>1. Компанийн барилга, байгууламж, дулаан, сантехник, усан хангамжийн шугам хоолой, хэрэгслийн засвар, үйлчилгээг хариуцах.</p> <p>2. Компанийн барилга, байгууламж, дотоод дулаан, сантехник, усан хангамжийн шугам хоолой, хэрэгслийн засварын ажилд хяналт тавих.</p> <p>3. Компанийн барилга, байгууламжийн битүүмжлэл, өнгө үзэмж, суулт, ан цав үүсч буй байдал, дотоод дулаан хангамж, сантехник усан хангамжийн шугам хоолой, хэрэгслэлд тогтмол үзлэг хийж илэрсэн зөрчлийг арилгах ажлыг зохион байгуулах.</p> <p>4. Нэгжүүдээс барилга, байгууламжийн битүүмжлэл, өнгө үзэмж, суулт, ан цав үүсч буй байдал, дотоод дулаан хангамж, сантехник усан хангамжийн шугам хоолой, хэрэгслэлтэй холбоотой эвдрэл гэмтэл, засварын санал хүлээн авч, засварлах ажлуудыг зохион байгуулах.</p> <p>5. Барилга, дотоод дулаан хангамж, сантехникийн засварын ажлын үед ХАБЭА-н тухай хууль, ТАД, ААД, ГАУСТ, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн норм стандартыг мөрдүүлж ажиллах.</p>	<p>Боловсрол: Дээд боловсролын бакалавраас доошгүй зэрэгтэй байх.</p> <p>Мэргэжил: Барилга, сантехник, дулааны инженер</p> <p>Мэргэшил: Мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан. Төсөв зохиох эрхтэй.</p> <p>Туршлага: Техник технологийн болон онол, практикийн мэдлэгтэй, зохион байгуулах авьяас чадвартай.</p>
1	2	3	4	5	6	7	8	9	10	11

									<p>6. Барилга, байгууламж, дотоод дулаан хангамж, сантехник усан хангамжийн шугам хоолой, хэрэгслэлийн засварын зардалын төсөв гаргаж, арвилан хэмнэлт, үр ашгийг нэмэгдүүлэх бодлого баримтлан ажиллах.</p> <p>7. Жил бүрийн засварын ажлын эзлэхүүнийг тодорхойлох, гүйцэтгэлд хяналт тавих, хэрэгжилтийг хангах.</p> <p>8. Барилга байгууламжийн техникийн нөхцөлийг тодорхойлох.</p> <p>9. Халаалтын улирал эхлэхийн өмнө дотоод хэрэгцээний дулаацуулгын тохируулгыг хийх.</p> <p>10. Барилга, байгууламжуудын агааржуулалтын хоолойд үзлэг хийх, засвар үйлчилгээний ажлыг зохион байгуулах.</p> <p>11. Хариуцсан ажлаа жил, улирал, сар, 7 хоног, өдөрөөр төлөвлөж гүйцэтгэх.</p>	
	79		Станцын тоног төхөөрөмжийн засварчин	VI	1	11	Хүнд	Үндсэн болон туслах тоноглолуудын эвдрэл гэмтлийг шуурхай засах, ажиллагаанд оруулах.	<p>Өрлөг тусгаарлалтыг зургийн дагуу, параметрын зуухны өрлөгийн засвар хийх, шаардлагатай материалыг сонгох, галд тэсвэртэй нарийн зуурмаг бэлтгэх, өрлөг тусгаарлалтын ажлыг гүйцэтгэх, тоног төхөөрөмжийн эд ангийг задлах, угсрах, тохируулга хийх, шалгалтын хийн, усны хаалтуудын засвар, тусгай эд ангийг өөрчлөх, солих, халах гадаргууг засах, шалгах, гэмтлийг илрүүлэх ,гар болон цахилгаан таль ажиллуулах, сантехникийн</p>	Бүрэн бус дунд ба түүнээс дээш боловсролтой, бичиг үсгийн уншиж, бичих чадвартай, ЭХТСҮЦогцолборт тоног төхөөрөмжийн засварчны мэргэжилтэй, даралтат савыг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрмийн сургалтад хамрагдаж үнэмлэхжсэн байх, тоноглолын
	80	V		3		Хүнд				
	81	IV		8		Хүнд				
1	2	3	4	5	6	7	8	9	10	11

									засвар үйлчилгээ хийх, шугам хоолойд нягтруулга хийх, эргэх механизмыг турших, засварлагдсан тоног төхөөрөмжийг шалгах, түүнийг ашиглалтад өгөх ажлыг гүйцэтгэнэ	гэмтэлийг илрүүлэх чадвар эзэмшсэн, гал унтраагуур ашиглах чадвартай, хараа, сонсгол, амьсгалын замын болон зүрх судасны архаг үрэвсэл, харшилгүй, эрүүл чийрэг, сэтгэцийн ямар нэгэн өөрчлөлтгүй байх.
	82		Гагнуурчин	VI	1		Хүнд	Үндсэн болон туслах тоноглолуудын эвдрэл гэмтлийг шуурхай засах, гагнах, ажиллагаанд оруулах.	Метал эд анги, нүүрстөрөгч гангаар хийгдсэн хийц, зангилгаа, эд ангийг гагнах, тусгай зориулалтын ган ба металаар хийгдсэн дунд зэргийн төвөгтэй эд ангийг төрөл бүрийн байрлалд өөлж огтлох, багаж эд ангийн элэгдэлд гагнаас хийх, динамик чичиргээт ачаалал болон даралтад ажиллахад зориулагдсан ган ширэм өнгөт металл тэдгээрийн хайлшаар хийсэн нарийн төвөгшилтэй хариуцлагатай багаж хэрэгсэл, эд анги, зангилаа хийцүүдийг нум хийгээр гагнах.	Бүрэн бус дунд ба түүнээс дээш боловсролтой, ЭХТСҮЦогцолборт Гагнуурчны мэргэжлийн сургалтанд хамрагдаж III-V зэргийн гагнуурчны үнэмлэх авсан, даралтат савыг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрмийн сургалтад тус тус хамрагдаж үнэмлэхжсэн байх, тоноглолын гэмтэлийг илрүүлэх чадвар эзэмшсэн, гал унтраагуур ашиглах чадвартай, станцын зуухны тоног төхөөрөмжийн III зэргийн гагнуурчны ажил үүрэг гүйцэтгэх, хараа, сонсгол, амьсгалын замын болон зүрх судасны архаг
	83	V		3	6	Хүнд				
	84	IV		2	Хүнд					
1	2	3	4	5	6	7	8	9	10	11

										үрэвсэл, харшилгүй, эрүүл чийрэг, сэтгэцийн ямар нэгэн өөрчлөлтгүй байх.
Хими хэсэг	85	14	Химийн инженер	ИТА	1	1	Хүнд	<p>Станцын үйлдвэрлэлийн тасралтгүй, хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор сүлжээний усны горим, чанарыг норм, стандартын дагуу мөрдүүлэх, ус боловсруулах тоноглолын хэвийн найдвартай ажиллагааг хангуулах, түлшний шинжилгээг стандарт, батлагдсан зааврын дагуу хийлгэж, холбогдох цех нэгжүүдэд мэдээлэл өгөх, шугам хоолой, хаалт арматур, тоноглолд зэврэлт явагдах, хаг хусам тогтох, шугам хоолой гэмтэх, эдийн засгийн үзүүлэлт буурахаас сэргийлэх ажлыг батлагдсан журам, зааврын дагуу чанартай зохион байгуулах.</p>	<p>Усны химийн горимыг барьж ажиллах, ус, түлшний шинжилгээг стандарт, заавар, графикын дагуу хийлгэх. 2. Хими ус бэлтгэлийн тоног төхөрөөмжийн горимын картыг мөрдөж ажиллуулах. 3. Нүүрсний шинжилгээг заавар, стандартын дагуу хийлгэж, дүгнэлт гаргах. 4. Технологийн ус, түлшний чанар, стандартад шинжилгээний үндсэн дээр хяналт тавих, сайжруулах арга хэмжээ авах, хэрэглэгч албан тушаалтан, хангагч байгууллагад мэдэгдэл, шаардлага, зөвлөмж өгөх. 5. Химийн багаж, тоног төхөөрөмжүүдийн бүрэн бүтэн байдал, баталгаажилтыг хариуцах. 6. Химийн горимыг тогтворжуулах, сайжруулах зорилгоор ус-химийн туршилт, тохируулга, угаалга цэвэрлэгээ хийх ажлыг зохион байгуулах, хяналт тавих. 7. Хариуцсан ажлын байрны аюулгүй байдал, эрүүл ахуй, галын аюулгүй байдал, химийн хорт бодистой харьцах аюулгүй ажиллагааг хариуцна. 8. Аюулгүй байдалд тогтмол хяналт тавьж, аюулыг арилгах арга хэмжээг тухай бүр нь авах.</p>	<p>Боловсрол: Дээд боловсролын бакалавраас доошгүй зэрэгтэй байх. Мэргэжил: Аналитик хими, Хими технологи Мэргэшил: Дулааны ус боловсруулалтын технологи болон химийн горим барилтын чиглэлээр мэргэшсэн байх. Туршлага: Мэргэжлээрээ болон Эрчим хүчний салбарт 7-оос доошгүй жил ажилласан байх.</p>
1	2	3	4	5	6	7	8	9	10	11

									9. Ашиглалтын заавар, ТАД-д заасан чанарын нормыг мөрдүүлэх. 10. Хими хэсэгт ашиглагдаж байгаа эд хөрөнгө, багаж хэрэгслэл хариуцах. Бүрэн бүтэн байдлыг хариуцах.	
	86		Химийн техникч	Техникийн ажилтан	1	1	Хүнд	Станцын үйлдвэрлэлийн тасралтгүй ажиллагааг хангахад сүлжээний усны чанарын нормыг үйлдвэрийн хэмжээнд мөрдөх, ус боловсруулах тоноглолын хэвийн найдвартай ажиллагааг хангах, түлшний шинжилгээг стандарт, батлагдсан зааврын дагуу хийж мэдээллээр	1. Химийн горим тогтоох, тохируулах зорилгоор өөрчилсөн горим бүрийн үед усны шинжилгээг хийж ТАД, ТЭЗҮ-ийн ашигтай горим тогтоох боломжоор хангана. 2. Станцын сүлжээний ус, нэмэлт ус, түүхий болон давсгүйжүүлсэн, зөөлрүүлсэн, хаягдал усны шинжилгээнд шаардлагатай уусмалуудыг стандартын дагуу бэлтгэнэ. 3. Сүлжээний усны химийн горимд хяналт тавих үйлдвэрлэгчийн ашиглалтын заавар, ТАД-д заасан чанарын нормыг мөрдөх, шинжилгээний дүгнэлт гаргах боломжоор хангана. 4. Станцын технологийн усны бүрэн шинжилгээнд шаардлагатай уусмал, тоног төхөөрөмж багаж хэрэгслийн баталгаажуулалт, тохируулгыг хийлгэж, шинжилгээ бодитой хийгдэх боломжийг хангаж, шинжилгээг үнэн зөв хийж ажиллана. 5. Химийн аппаратчин, химийн лаборантын, түлшний лаборантын ашиглалтын үйл ажиллагаа болон химийн горим барилтанд шаардлага тавьж үүрэг даалгавар өгч	Боловсрол: Дээд боловсролын бакалавраас доошгүй зэрэгтэй байх. Мэргэжил: Аналитик хими болон хими технологи мэргэжилтэй байх. Мэргэшил: Дулааны станцын ус боловсруулалтын технологи болон химийн горим барилтын чиглэлээр мэргэшсэн байх. Туршлага: Мэргэжлээрээ болон Эрчим хүчний салбарт 2-оос дээш жил ажилласан байх.
1	2	3	4	5	6	7	8	9	10	11

									гүйцэтгэлийн биелэлтэнд хяналт тавьж ажиллана. 6. Лабораторийн багаж, тоног төхөөрөмжүүдийн бүрэн бүтэн байдал, шинжилгээнд шаардлагатай урвалж бодис багаж хэрэгсэл, баталгаажилтыг хариуцах 7. Шинжилгээнд ашиглагдах техник хэрэгсэл, шил сав, урвалж бодисын хэрэгцээ, зарцуулалтын тайланг үнэн зөв гаргана.	
	87		Түлшний лаборант	V	2	12	Хортой	Дулаан үйлдвэрлэлийн процесст зуухыг шаардлага хангасан нүүрсээр хангах.	Уурхайгаас тээвэрлэгдэн ирсэн, туузан дамжлагаар тээвэрлэгдэж буй, гадна талбайд хадгалагдаж байгаа нүүрсний техникийн анализын бүрэн шинжилгээг стандартын дагуу хийж, дүгнэлт гаргана.	Бүрэн дунд ба түүнээс боловсролтой, дулаан техникийн мэдлэгтэй, химийн чиглэлээр болон Химийн технологийн чиглэлээр мэргэжлээрээ 1-ээс доошгүй жил ажилласан байх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөв дадал эзэмшсэн, хараа, сонсгол, амьсгалын замын болон зүрх судасны архаг үрэвсэл, харшилгүй, эрүүл чийрэг, сэтгэцийн ямар нэгэн өөрчлөлтгүй байх.
	88			IV	2		Хортой			
	89		Химийн лаборант	IV	4		Хортой	Дулаан үйлдвэрлэлийн процесст зуухыг шаардлага хангасан усаар тасралтгүй найдвартай хангах.	Эрчим хүчний техник ашиглалтын дүрэмд заагдсан дулааны станц болон дулааны шугам сүлжээний усны	Бүрэн дунд болон түүнээс дээш боловсролтой, ЭХСҮЦогцолборыг
1	2	3	4	5	6	7	8	9	10	11

									чанарын нормыг үйлдвэрийн хэмжээнд мөрдөх, хэрэгжүүлэх, ээлжийн хугацаанд цахилгаан станцын уур, усны химийн горимд батлагдсан графикаар хяналт тавих ажлыг биечлэн гүйцэтгэнэ.	аппаратчин, лаборантын мэргэжил олгох курст суралцсан, тооцоо судалгаа, дүн шинжилгээ хийж үнэлэлт гаргах, орчин үеийн техник хэрэгслийг ажлын байранд сайн ашиглах, харилцааны ур чадвартай, гарч буй өөрчлөлтөнд зохицон ажиллах чадвартай, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөв дадал эзэмшсэн, хараа, сонсгол, амьсгалын замын болон зүрх судасны архаг үрэвсэл, харшилгүй, эрүүл чийрэг, сэтгэцийн ямар нэгэн өөрчлөлтгүй байх.
	90		Химийн аппаратчин	IV	4		Хүнд	Дулаан үйлдвэрлэлийн процесст зуухыг усаар тасралтгүй найдвартай хангах.	Дулааны станц болон Дулааны шугам сүлжээний усны гадаад дотоод усны алдагдалыг нөхөх, чанарын шаардлага хангасан цэвэр усаар үйлдвэрийг тасралтгүй хангаж, эрчим хүчний техник ашиглалтын дүрэмд заагдсан нэмэлт усны чанарын нормыг мөрдөж ажиллах. Дулааны шугам сүлжээ, ус боловсруулах төхөөрөмжийг зөөлрүүлэх схемээр ион солилцооны аргаар	Бүрэн дунд боловролоос дээш зэрэгтэй, Эрчим хүчний сургалтын мэргэжил олгох курст хамрагдсан, дулааны техникийн бакалавр зэрэгтэй, дулаан-техник болон хими ус боловсруулалтын технологийн мэдлэгтэй байх,
1	2	3	4	5	6	7	8	9	10	11

182	Дашсэрмаа Анхзала	Химийн аппаратчин		Бакалавр	1.Тавар судлал 2.Химийн лаборант, аппаратчин /IV/	1.ХААИС 2.ЭХХТ-ЭХСҮТөв	1.Тавар судлал мэргэжлээр бакалаврын зэргийн боловсролтой. 2.ЭХХТ-ЭХСҮТөвийн химийн лаборант, аппаратчны мэргэжил олгох сургалтанд хамрагдсан. 3.Мэргэжлээрээ 6,3 жил ажилласан. 4.Даралтат савтай харьцах АА-ны сургалтанд хамрагдсан.	1.Бүрэн дунд ба түүнээс дээш боловсролтой. 2.ЭХХТ-ЭХСҮТөвийн химийн лаборант, аппаратчны мэргэжил олгох сургалтанд хамрагдсан. 3.Мэргэжлээрээ 1-ээс доошгүй жил ажилласан байх ажлын байрны шаардлагыг бүрэн хангаж байна.

183	Баатар Баярчимэг	Химийн аппаратчин		Бүрэн дунд	1.Амгалан цогцолбор		1.Бүрэн дунд боловсролтой. 2.ЭХХТ-ЭХСҮТөвийн химийн лаборант, аппаратчины мэргэжил олгох сургалтанд хамрагдсан. 3.Мэргэжлээрээ 2 жил ажилласан. 4.Даралтат савтай харьцах АА-ны сургалтанд хамрагдсан.	1.Бүрэн дунд боловсролтой. 2.ЭХХТ-ЭХСҮТөвийн химийн лаборант, аппаратчины мэргэжил олгох сургалтанд хамрагдсан. 3.Мэргэжлээрээ 2 жил ажилласан. 4.Даралтат савтай харьцах АА-ны сургалтанд хамрагдсан. ажлын байрны шаардлагыг бүрэн хангаж байна.
184	Сумъяасүрэн Цэрэнлуцаг	Сорьц бэлтгэгч	1.Тусгай дунд ба түүнээс дээш боловсролтой.	Бакалавр	1.Хими технологи	1.ШУТИС	1.Хими технологийн мэргэжлээр бакалаврын зэргийн боловсролтой. 2.Даралтат савтай харьцах АА-ны сургалтанд хамрагдсан. 3.ЭХХТ-ЭХСҮТөвийн химийн лаборант, аппаратчины мэргэжил олгох сургалтанд хамрагдсан.	ЭХХТ-ЭХСҮТөвийн химийн лаборант, аппаратчины мэргэжил олгох сургалтанд хамрагдсан байх ажлын байрны шаардлагыг бүрэн хангахгүй байна.
185	Намбардагва Гомбосүрэн	Зуухны машинч		Бакалавр	Дулааны цахилгаан станц	ШУТИС	1. ДЦС мэргэжилтэй. 2. ЭХСургалтын төвийн зуухны машинчийн сургалтанд хамрагдсан. 3. Даралтат савтай харьцах АА-ны сургалтанд хамрагдсан. 4. Тус станцад 6 жил 3 сар ажилласан.	1. ДЦС мэргэжилтэй. 2. ЭХСургалтын төвийн зуухны машинчийн сертификаттай 3. Даралтат савтай харьцах АА-ны сургалтанд хамрагдсан. 4. Тус станцад 6 жил 3 сар ажилласан ажлын байрны шаардлагыг бүрэн хангаж байна.
186	Батгэрэл Оюун-Эрдэнэ	Зуухны машинч		Магистр	Дулааны цахилгаан станц	ШУТИС	1.ДЦС мэргэжилтэй. 2. ЭХСургалтын төвийн зуухны машинчийн сургалтанд хамрагдсан 3. Даралтат савтай харьцах АА-ны сургалтанд хамрагдсан. 4. Тус станцад 6 жил 3 сар ажилласан.	1.ДЦС мэргэжилтэй. 2. ЭХСургалтын төвийн зуухны машинчийн сертификаттай 3. Даралтат савтай харьцах АА-ны сургалтанд хамрагдсан. 4. Тус станцад 6 жил 3 сар ажилласан ажлын байрны шаардлагыг бүрэн хангаж байна.
187	Сумъяасүрэн Цэрэндулам	Зуухны машинч		Бакалавр	Үйлдвэр хотын дулаан хангамж	ШУТИС	1. Үйлдвэр, хотын дулаан хангамж мэргэжилтэй. 2. ЭХСургалтын төвийн зуухны машинчийн сургалтанд хамрагдаж төгссөөгүй. 3. Даралтат савтай харьцах АА-ны сургалтанд хамрагдсан. 4. Тус станцад 6 жил 3 сар ажилласан.	1.ЭХСургалтын төвийн зуухны машинчийн сургалтанд хамрагдаагүй тул ажлын байранд тавигдах шаардлагыг бүрэн хангахгүй байна.
188	Баасанжав Мөнх-Эрдэнэ	Туслах тоноглолын машинч		Бакалавр	Дулааны процессын автоматжуулалтын инженер	ШУТИС	1. ДЦС мэргэжилтэй. 2. ЭХСургалтын төвийн зуухны машинчийн сургалтанд хамрагдсан 3. Даралтат савтай харьцах АА-ны сургалтанд хамрагдсан.	1. ДЦС мэргэжилтэй. 2. ЭХСургалтын төвийн зуухны машинчийн сертификаттай 3. Даралтат савтай харьцах АА-ны сургалтанд хамрагдсан ажлын байрны шаардлагыг бүрэн хангаж байна.
189	Ганжамъян Уртнасан	Насосны машинч		Бакалавр	Дулааны цахилгаан станц	Үндэсний техникийн их сургууль	1. ДЦС мэргэжилтэй. 2. ЭХСургалтын төвийн зуухны машинчийн сургалтанд хамрагдсан 3. Даралтат савтай харьцах АА-ны сургалтанд хамрагдсан.	1. ДЦС мэргэжилтэй. 2. ЭХСургалтын төвийн зуухны машинчийн сургалтанд хамрагдаж төссөн байх 3. Даралтат савтай харьцах АА-ны сургалтанд хамрагдсан. ажлын байрны шаардлагыг бүрэн хангаж байна.
190	Батнасан Өлзийсайхан	Зуухны тоног төхөөрөмжийн засварчны дагалдан		Бакалавр	Дулааны цахилгаан станц	ШУТИС	1. Дээд боловсролтой, ДЦС мэргэжилтэй. 4. ЭХС-т 3 сар ажилласан.	1. Бүрэн дундаас дээш боловсролтой байх. 2. ЭХСургалтын төвд мэргэжлийн сургалтанд хамрагдсан байх. 3. Даралтат савтай харьцах АА-ны сургалтанд хамрагдсан байх. 4. ЭХС-т 4-өөс доошгүй жил ажилласан байх ажлын байрны шаардлагыг бүрэн хангаж байна.

АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-ИЙН SWOT ШИНЖИЛГЭЭ

ДАВУУ ТАЛ /STRENGTH/:

1. Компанийн нэр хүнд сайн.
2. Инновацийг дэмждэг.
3. Ур чадвартай, мэргэшсэн ажилтнуудтай.
4. Ажилтнуудын нийгмийн баталгаа сайн, тогтвор суурьшилтай.
5. Нөөцийн удирдлагын нэгдсэн программ хэрэглэдэг.(ERP)
6. Итгэмжлэгдсэн лабораториудтай.
7. Үндсэн түүхий эдийн нөөц хангалттай.
8. Байгаль орчинд ээлтэй эко, бүрэн автомат тоног төхөөрөмжтэй.
9. УБ хотын зүүн бүсийг дулааны эрчим хүчээр хангадаг.
10. Эрчим хүчний шинэ эх үүсвэр тул барилга байгууламж, тоног төхөөрөмж, машин механизмын насжилт бага.
11. 20,000 тн нүүрс хадгалах битүү агуулахтай.
12. Аль ч үүрхэйн нүүрсийг ашиглана.

СҮЛ ТАЛУУД /WEAKNESSES/:

1. Ажлын байрны нөхцөл эрсдэлтэй.
2. Бараа материал, багаж хэрэгслийн чанар, хүрэлцээ хангалтгүй.
3. Бодит тариф мөрдөгддөггүйгээс шинэчлэл, засварын ажлыг шаардлагатай хэмжээнд хийж чаддаггүй.
4. Баримт бичгийн хэрэгжилт, хяналт сул.
5. Мэргэжилтэй ажилтны бодлого алдагдсан. Ажиллагсдыг мэргэшүүлэх сургалт хангалтгүй.
6. Ажилд хандах хандлага жигд бус, ачаалал харилцан адилгүй.
7. Засварын ажилд тавих хяналт сул.
8. Ажил үүрэг, албан тушаал давхардалтай.
9. Цахилгаан эрчим хүч үйлдвэрлэдэггүй.
10. Техникийн ус хангамжийн нөөц бага.

БОЛОМЖ /OPPORTUNITY/:

1. МУЗГ-ын "Алсын хараа 20-50" Урт хугацааны хөгжлийн бодлогод тус станцын өргөтгөлийн ажил тусгагдсан.
2. Дулааны эрчим хүчний өөрийн түгээлтийг нэмэгдүүлэх.
3. Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас хамааруулан техник эдийн засгийн үзүүлэлтийг дээшлүүлэх, ашигт ажиллагааг сайжруулах.
4. Техникийн томоохон шийдлийг боловсруулж, хэрэгжүүлэх чадамжтай.
5. Хоёрдогч түүхий эд болон үнс борлуулах.
6. УБ хотын зүүн бүс орон сууцжиг, тэлж байгаа тул дулааны эрчим хүчний хэрэглээ жил бүр өсч байгаа.
7. Ажлын байрны нөхцлийг сайжруулах.
8. Мэргэжлийн чиглэлээр зөвлөх үйлчилгээ үзүүлэх.
9. Дэд бүтэц сайн хөгжсөн.

АЮУЛ/THREATS/:

1. Аварь, саатал гарсан тохиолдолд Эрчим хүчний системийн горим ажиллагаанд шууд нөлөөлдөг.
2. Мэдээллийн технологийн аюулгүй байдал эрсдэлтэй.
3. Анх баригдахдаа үнсэн сан төлөвлөж хийгээгүй.
4. Улиастайн голын ай савд баригдсан тул үер, байгалийн гамшигт өртөх.
5. Галын аюулын эрсдэл өндөр.
6. Аварь, саатлын үед иргэдэд нөлөөлөх.
7. Засвар хийх чадамжтай компанийн тоо хязгаарлагдмал.
8. Түүхий эдийн нөөц алслагдсан.
9. Онцгой объект тул гадны халдлагад өртөх аюултай.
10. Цахилгааны эрчим хүчнээс хараат.


АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-ИЙН **CROSS SWOT** ШИНЖИЛГЭЭ

Гадаад Дотоод	БОЛОМЖ: 1. МУЭГ-аас гаргасан "Алсын хараа 20-50" Урт хугацааны хөгжлийн бодлогод тус станцын өрсөтсөлийн ангил тусгагдсан. 2.Цахилгаан, дулааны эрчим хүч хослон үйлдвэрлэхээр өрсөтгөх. 3.Техникийн томоохон шийдлийг боловсруулж, хэрэгжүүлэх чадамжтай 4. Дулааны эрчим хүчний түгээлтэйг нэмэгдүүлэх. 5. УБ хотын зүүн бүс орон сууцнаж, илжмэ байгаа тул дулааны эрчим хүчний хэрэглээ жил бүр өсч байгаа.	АЮУЛ: 1.Аварь, спатил гарсан тохиолдолд эрчим хүчний системийн горим ажлаллагаанд шууд нөлөөлдөг. 2.Цахилгааны эрчим хүчнээс хараат. 3.Галын аюулын эрсдэл өндөр. 4.Мэдээллийн технологийн аюулгүй байдал эрсдэлтэй. 5.Түүхий эдийн нөөц алслагдсан.
ДАВУУ ТАЛ: 1.Байгаль орчинд ээлтэй эко, бүрэн автомат дэвшилтэт технологи. 2.Эрчим хүчний шинэ эх үүсвэр тул барилга байгууламж, тоног төхөөрөмж, машин механизмын насжилт бага. 3.Хаана ч байхгүй 20,000 тн нүүрс хадгалах битүү агуулахтай. 4.УБ хотын зүүн бүсийг дулааны эрчим хүчээр хангадаг. 5.Аль ч зурхайн нүүрсийг ашиглана.	1. Байгаль орчинд ээлтэй эко, бүрэн автомат дэвшилтэт технологвор цахилгаан, дулааны эрчим хүч хослон үйлдвэрлэхээр өргөтгөлийн ажлыг хийх. 2. ШБОС гарган, техникийг шинэчлэх. 3. Барилга, байгууламж, тоног төхөөрөмж, машин механизмын насжилтыг уртасгахын тулд засварын ажлыг чавартай гүйцэтгэх. 4. Нүүрсний шинж чаварыг алдагдуулахгүйгээр битүү агуулахад хадгалж дулааны эрчим хүч үйлдвэрлэж, ашигт ажиллагааг нэмэгдүүлэх. 5. УБ хотын зүүн бүсийн шинэ хэрэглэгчдийг дулааны эрчим хүчээр хангах. 6. Шинээр ашиглалтад орж буй ижил төстэй дулааны станцуудад уурхайнуудын нүүрс ашиглалтад горим тооцоо хийж, мэргэжлийн чиглэлээр зөвлөх үйлчилгээ үзүүлэх.	1.Аварь саатлаас урьдчилан сэргийлж, үзлэг, үйлчилгээг цаг тухай бүрт нь хийх. 2.Дулааны эрчим хүчний тарифыг нэмэгдүүлснээр засварын ажлыг чавартай гүйцэтгэх. 3.Цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх өргөтгөлийн ажлыг эхлүүлэх. 4. Аюулгүй ажиллагааг сайжруулах. 5.Мэдээллийн технологийн аюулгүй байдлыг хангаж ажиллах. 6.Боловсон хүчнийг сургаж, мэргэшүүлэн бэлтгэх. 7.Түүхий эд-нүүрсний татан авалт, нөөцлөлтийг нэмэгдүүлэх.
СУЛГАЛ: 1. Бодит тариф мөрдөгддөггүйгээс шинэчлэл, засварын ажлыг шаардлагатай хэмжээнд хийж чадаагүй. 2. Цахилгаан эрчим хүч үйлдвэрлэхгүй. 3. Ажлын байрны нөхцөл эрсдэлтэй. 4. Техникийн ус хангамжийн нөөц бага. 5. Мэргэжилтэй боловсон хүчний бодлого алдагдсан.	1. 50 МВт-ын Турбин суурьлуулж, цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх. 2. Инновацийг нэвтрүүлж, хэрэгжүүлэх. 3. Урсгал засварын ажлыг чанарын өндөр түвшин гүйцэтгэж, хүлээн авах. 4.Нүүрсний нөөцлөлтийг нэмэгдүүлэхийн тулд битүү агуулахыг өргөтгөх. 5. Шинээр ашиглалтад орсон станцуудад туршинг тохируулгын ажлыг гүйцэтгэж, тухайн бйагууллагын боловсон хүчнийг сургаж, бэлтгэх.	1. I, II, III шатны аюулгүй ажиллагааны үзлэг, шалгалтыг сайжруулж, биелэлтийг хангуулах. 2. Цахилгааны эрчим хүч үйлдвэрлэх ТЭЗҮ-ийг боловсруулж, батлуулах. 3. Цахилгааны эрчим хүч үйлдвэрлэх өргөтгөлийн ажлын хөрөнгө оруулалтыг шийдвэрлүүлэх. 4. Аюулгүй ажиллагааны стандартуудыг нэвтрүүлэх. 5. Шинээр гүний худаг гаргах. 6. Техникийн ус нөөцлөх багыг нэмэгдүүлэх. 7. Боловсон хүчний нөөц бүрдүүлэх. 8. Ажилтнуудыг мэргэшүүлэх, сургах, бэлтгэх. 9. Нарийн мэргэжлийн инженерүүдийн залгамж халааг бэлтгэх. 10. Уурхайнуудаас швардлага хангасан нүүрсийг захиалж, татан авах.

**АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-ИЙН
ХҮНИЙ НӨӨЦИЙН (SWOT) ШИНЖИЛГЭЭ**

Давуу тал	Сул тал
<ol style="list-style-type: none"> 1. Ажилтнуудын 57 хувь нь дээд сургууль, түүний дотроос Эрчим хүчний мэргэжлийн дээд сургууль төгссөн ажилтнууд нийт ажилтнуудын 45 хувийг эзэлдэг 2. Ажилтнуудын 74 хувь нь 40 хүртэлх насны залуу боловсон хүчин эзэлдэг 3. Бусад ижил төстэй дулааны станцууд дотроос илүү дэвшилтэт технологтой 4. Бусад ижил төстэй дулааны станцууд дотроос ажлын байрны нөхцөл илүү сайн 5. Бусад ижил төстэй дулааны станцууд дотроос илүү дэвшилтэт техник-технологичор тоноглогдсон 6. Засварын хэсгийн ажилтнуудыг сүүлийн жилүүдэд хос мэргэжил эзэмшүүлэх сургалтанд хамруулсан тул хөрвөх чадвартай боловсон хүчин болсон. 	<ol style="list-style-type: none"> 1. Ажилтнуудын дийлэнх олонхийг залуу боловсон хүчин эзэлдэг тул ажлын байранд алдаа гаргах, аваар осол гаргах магадлал өндөр 2. Мэдлэг шаардсан техник-технологи дээр ажилладаг тул ажилдаа хурдан дадлагжих шаардлагатай 3. Ажлын байрнуудын зэргийн цалин нь ажлын хүнд хөнгөн, хариуцлагаас хамаарсан ялгаа байхгүй, ажилласан хугацаа, дадлага туршлагаас хамаарсан цалингийн интерваль байхгүй тул цаашид тэмүүлэх тэмүүлэл хязгаарлагдсан 4. Шинэ залуу боловсон хүчнүүд нь хос мэргэжил эзэмшээгүй байдаг тул оройн цагаар жижиг гэмтэлд ажилтан дуудаж ажиллуулах, түүнд илүү цагийн хөлс олгуулах 5. Албан тушаал дэвших карьерийн тогтолцоо байхгүй 6. Эрчим хүчний системд мөрдөгддөг дүрэм, журамтай нийцсэн дүрэм, журам, заавар боловсрогдож, гарын авлага болж гараагүй 7. Гадаад дотоодын ижил төстэй дулаан үйлдвэрлэгчдийн туршлага судлах ажил хийгддэггүй
Боломж	Аюул, занал
<ol style="list-style-type: none"> 1. Улс орны хөгжлийн чиг хандлагатай уялдан тус станц нь өргөтгөл хийх, цахилгаан станц болох ирээдүйтэй тул ажлын байр нэмэгдэх боломжтой 2. Станц нь өргөтгөл хийсэн тохиололд өнөөдрийн залуу боловсон хүчнүүд тухайн үед дадлага туршлагаараа үнэлэгдэж тушаал дэвшин ажиллах нөхцөл бүрдэнэ 	<ol style="list-style-type: none"> 1. Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа улирлын шинж чанартай байгаа учир бэлтгэгдсэн мэргэжилтэй боловсон хүчнүүд нь байнгын ажлын байртай байгууллагад шилжин орох аюултай

СТРАТЕГИЙН ТОМЪЁОЛОЛ



МЕКСОНЫ 5*5 АРГА

ХАМГИЙН ЧУХАЛ

5 БОЛОМЖ	5 АЮУЛ	5 ДАВУУ ХҮЧИН ЗҮЙЛ	5 СУЛ ХҮЧИН ЗҮЙЛ
МУЗГ-ын "Алсын хараа 20-50" Урт хугацааны хөгжлийн бодлогод тус станцын өргөтгөлийн ажил тусгагдсан.	Аваари, саатал гарсан тохиолдолд эрчим хүчний системийн горим ажиллагаанд шууд нөлөөлдөг.	Байгаль орчинд ээлтэй эко, бүрэн автомат дэвшилтэт технологи.	Бодит тариф мөрдөгддөггүйгээс шинэчлэл, засварын ажлыг шаардлагатай хэмжээнд хийж чаддаггүй.
Техникийн томоохон шийдлийг боловсруулж, хэрэгжүүлэх чадамжтай.	Цахилгааны эрчим хүчнээс хараат.	Эрчим хүчний шинэ эх үүсвэр тул барилга байгууламж, тоног төхөөрөмж, машин механизмын насжилт бага.	Цахилгаан эрчим хүч үйлдвэрлэдэггүй.
Дулааны эрчим хүчний түгээлтийг нэмэгдүүлэх.	Галын аюулын эрсдэл өндөр.	20,000 тн нүүрс хадгалах битүү агуулахтай.	Ажлын байрны нөхцөл эрсдэлтэй.
УБ хотын зүүн бүс орон сууцжиж, тэлж байгаа тул дулааны эрчим хүчний хэрэглээ жил бүр өсч байгаа.	Мэдээллийн технологийн аюулгүй байдал эрсдэлтэй.	УБ хотын зүүн бүсийг дулааны эрчим хүчээр хангадаг.	Техникийн ус хангамжийн нөөц бага.
Мэргэжлийн чиглэлээр зөвлөх үйлчилгээ үзүүлэх.	Түүхий эдийн нөөц алслагдсан.	Аль ч уурхайн нүүрсийг ашиглана.	Мэргэжилтэй боловсон хүчний бодлого алдагдсан.

МЕКСОНЫ 5*5 АРГА

ХАМГИЙН ЧУХАЛ 5 ЗҮЙЛС

Нэг. МУЗГ-аас гаргасан "Алсын хараа 20-50" Урт хугацааны хөгжлийн бодлого. Цахилгаан, дулааны эрчим хүч хослон үйлдвэрлэхээр өргөтгөх.

Хоёр. Мэргэжилтэй боловсон хүчний бодлого алдагдсан. Ажиллагсдыг мэргэшүүлэх сургалт хангалтгүй.

Гурав. Аваари, саатал гарсан тохиолдолд эрчим хүчний системийн горим ажиллагаанд шууд нөлөөлдөг.

Дөрөв. Байгаль орчинд ээлтэй эко, бүрэн автомат дэвшилтэт технологи.

Тав. Түүхий эдийн нөөц алслагдсан.



ҮНЭТ ЗҮЙЛС:

Нэг. Найдвартай эрчим хүч

Хоёр. Мэргэжилтэй боловсон хүчин

Гурав. Эко, бүрэн автомат дэвшилтэт технологи.

Дөрөв. Түүхий эд-нүүрс

Тав. Аюулгүй горим ажиллагаа



ЭРХЭМ ЗОРИЛГО

Хэрэглэгчдийг чанартай, найдвартай эрчим хүчээр хангаж, мэргэшсэн аюулгүй ажиллагааг дээдэлсэн компани байна.



АЛСЫН ХАРАА

Цахилгаан, дулааны эрчим хүч хослон үйлдвэрлэнэ.


АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-ИЙН BSC ОНОЛ

№	Хөгжлийн зорилго	Хөгжлийн асуудал	Хариуцах эзэн	Гүйцэтгэлийн үнэлгээ	Үнийн дүн сая.төг	Хүрэх үр дүн
	Менежмент-Техник, технологийн нөөцөд тулгуурлан үйлдвэрлэлийг үр ашигтай, хэвнйн найдвартай, тасралтгүй явуулахад оршино.	<p>1.Урт, дунд, богино хугацааны стратеги төлөвлөгөө боловсруулах, үнэлгээ, шинжилгээ, дүгнэлт хийх, үр дүнг тооцох, хэрэгжилтийг хангах.</p> <p>2.Компанийн үйлдвэрлэл, үйл ажиллагааг үр ашигтай төлөвлөх, удирдан явуулахад шаардлагатай менежментийн бодлого, эдийн засаг, төсөв санхүүгийн тогтвортой хөгжлийн бодлого хэрэгжүүлэх.</p> <p>3.Компанийн үйлдвэрлэл, үйл ажиллагаа явагдах үндсэн суурь болох техник, тоног төхөөрөмж, технологио сайжруулж, хөгжүүлэх.</p> <p>4.Цахилгаан, дулааны эрчим хүчний цаашдын хэрэглээг хангахтай уялдуудан, компанийг өргөтгөх, өргөтгөл, шинэчлэлийн төслийг оновчтой төлөвлөн хэрэгжүүлэх.</p> <p>5.Амгалан Дулааны Станцыг 50МВт-аар өргөтгөж, ТЭЦ болгох төсөл хэрэгжүүлэх.</p>	ЭХЯ, Компанийн удирдлага	100%	53 тэрбум	50 МВт чадалтай шинэ ДЦС нь суурь болон хувьсах горимд ажиллах болно.
	Долоот үйл ажиллагааны зорилго-бодлогын баримт бичиг, хөгжлийн хөтөлбөрийг сайжруулж, хэрэгжилтийг хангах.	<p>1.Ажлын төлөвлөлтийг боловсронгуй болгож, гүйцэтгэлийг үнэлэх нэгдсэн систем тогтоож, үйлдвэрлэлийн бүтээмж, чанарыг дээшлүүлэх.</p> <p>2.Ажлын гүйцэтгэлийн удирдлага, зохион байгуулалтыг оновчтой болгох.</p> <p>3.Компанийн хэмжээнд мөрдөгдөж буй цалин хөлс, шагнал, урамшууллын тогтолцоог боловсронгуй болгох.</p> <p>4.Ажилтнуудын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг байгууллагын хэмжээнд хэрэгжүүлэх тогтолцоог бүрдүүлэх.</p> <p>5.Техникийн, санхүүгийн, хүний нөөцийн бодлогын баримт бичиг, хөгжлийн хөтөлбөрийг сайжруулж, нийт ажилтнуудад танилцуулан хэрэгжүүлэх.</p> <p>6. ISO стандартуудыг нэвтрүүлэх, хэрэгжүүлэх.</p>	Нэгжийн удирдлагууд, ИТА-ууд	100%	1,2 тэрбум	Удирдлагын менежментийн стандартыг мөрдөж, хэвшсэн байх.

АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-ИЙН BSC ОНОЛ

№	Хөгжлийн зорилго	Хөгжлийн асуудал	Хариуцах эзэн	Гүйцэтгэлийн үнэлгээ	Үнийн дүн сая.төг	Хүрэх үр дүн
	Хүний хөгжлийн зорилго -Компанийн эрхэм зорилго, төлөвлөгөөт зорилтыг ханган биелүүлэхэд ажил үүргийг мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэх чадавхтай хүний нөөцийг бүрдүүлэх, тэднийг сургах, хөгжүүлэх, идэвхжүүлэх, хүний нөөцийн мэдээллийн систем, техник технологийн өөрчлөлт, хөгжлийг нэвтрүүлэх замаар хүний нөөцийн удирдлагын үйл ажиллагааг сайжруулахад оршино.	<ol style="list-style-type: none"> 1.Компанийн үйлдвэрлэл, үйл ажиллагааг хөтлөн явуулах гол хөдөлгөгч хүч болсон хүнээ бүх талаар хөгжүүлэх. 2.Компанийн хөгжлийн хэтийн төлөвт нийцүүлэн бүтээлч сэтгэлгээ бүхий өрсөлдөх чадвартай мэргэжилтэнг бэлтгэх, дадлагажуулах, давтан сургах замаар чадварлаг хүний нөөц бүрдүүлэх, тэдний мэдлэг, ур чадварыг сайваруулах. 3.Ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх журам гарган хэрэгжүүлэх, тэдний тогтвор сууршилтай ажиллах нөхцөл хангах. 4.Гадаад болон дотоод орчинд гарч байгаа эрчимтэй өөрчлөлт, хөгжилтэй уялдуулан хүний нөөцийн хэрэгцээ, шаардлагыг оновчтой тодорхойлох. 5.Мэргэжлийн чадварлаг хүний нөөцийг бүрдүүлэх, ажлын байрны таатай орчинг бүрдүүлэх. 6.Карьер хөгжлийн бодлого, залгамж халааг бэлтгэх тогтолцоог нэвтрүүлэх. 7.Сургалтын чанарыг сайваруулах, шинэ технологигор баяжуулах. 8.Удирдах албан тушаалтны манлайллын чадварыг хөгжүүлэх. 	Захиргаа Удирдлагын хэлтсийн дарга	100%	230 сая	Хүний нөөцийн менежмент хэрэгжиж хэвшсэн байх.
	Санхүү, эдийн засгийн зорилго -Байгууллагын үндсэн зорилгыг хангах, үйлдвэрлэлийн болон бусад үйл ажиллагааг хэвийн үргэлжлүүлэх санхүү эдийн засаг, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулж, үр ашгийг нэмэгдүүлэхэд оршино.	<ol style="list-style-type: none"> 1.Компанийн үйлдвэрлэл, үйл ажиллагааг үр ашгтай төлөвлөх, удирдан явуулахад шаардлагатай менежментийн бодлого, эдийн засаг, төсөв санхүүгийн тогтвортой хөгжлийн бодлого хэрэгжүүлэх. 2.Компанийн Санхүү эдийн засгийн бодлого, НББ-ийн бодлогын баримт бичгийг сайваруулан боловсруулж, мөрдөж ажиллах. 3.Эдийн засгийн чадавхийг нэмэгдүүлэх. 4.Санхүүгийн тэнцвэртэй байдлыг хангах. 5.Төслийн санхүүжилт хөрөнгө татан төвлөрүүлэх. 6.Компанийн үйл ажиллагаа, зохион байгуулалтын онцлогийг харгалзан нягтлан бодох бүртгэлийн дансны жагсаалт, тэдгээрийг хөтлөх журам, дагаж мөрдөх хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, аргачлалыг боловсруулах ажлыг зохион байгуулах. 7.Борлуулалтын орлогыг нэмэгдүүлэх. 8.Үйл ажиллагааны бус орлого олж болох боломжийг үнэлэх. 9.Төсөв санхүүг төлөвлөх санхүү эдийн засгийн байдалд үнэлгээ, шинжилгээ, дүгнэлт хийх, үр дүнг тооцох, хэрэгжилтийг хангах. 	СЭЗХ-ийн дарга бөгөөд Ерөнхий нягтлан бодогч	100%	250 сая	Компанийн санхүү эдийн засаг тогтвортой болно.

ДУЛААНЫ СТАНЦЫН СТРАТЕГИЙН ЗУРАГЛАЛ



**АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-ИЙН
ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР /2025-2030/**

НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Хөтөлбөрийн зорилго
- 1.2 Хөтөлбөрийн үндэслэл, эрх зүйн орчин
- 1.3 Хөтөлбөрийн хэрэгцээ, хамрах хүрээ, хэрэгжүүлэх хугацаа
- 1.4 Хөтөлбөрийн хэрэгжилтийн үе шатанд үнэлгээ хийх

ХОЁР. ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ

- 2.1 Амгалан дулааны станц ТӨХК-ийн хүний нөөцийн бодлого, хөгжлийн тэргүүлэх чиглэл
- 2.2 Хүний нөөцийн хөгжлийн стратегийн зорилго

**ГУРАВ. АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦЫН ХҮНИЙ НӨӨЦИЙГ ХӨГЖҮҮЛЭХ
СТРАТЕГИЙН ЗОРИЛТ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ,
ХҮРЭХ ҮР ДҮН**

- 3.1 Хүний нөөцийн төлөвлөлт, бүрдүүлэлт, мэргэжлийн залгамж халааг бэлтгэх, тогтвортой ажиллуулах хүрээнд
- 3.2 Хүний нөөцийн сургалт, хөгжлийн бодлогыг тасралтгүй үе шаттай хэрэгжүүлэх хүрээнд
- 3.3 Ажлын гүйцэтгэлийн удирдлага, зохион байгуулалтыг оновчтой болгох хүрээнд
- 3.4 Цалин хөлс, шагнал, урамшууллын системийг боловсронгуй болгох хүрээнд
- 3.5 Хүний нөөцийн мэдээллийн систем, техник технологийн өөрчлөлт, хөгжлийг нэвтрүүлэх хүрээнд
- 3.6 Хүний нөөцийн удирдлага, хяналтыг сайжруулах хүрээнд

**ДӨРӨВ. ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨРИЙН
САНХҮҮЖИЛТ, ҮР ДҮН**

- 4.1 Хөтөлбөрийн санхүүжилт
- 4.2 Хөтөлбөрийн үр дүн

**ХАВСРАЛТ: АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-ИЙН ХҮНИЙ НӨӨЦИЙН
СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭ**

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Хөтөлбөрийн зорилго

Компанийн эрхэм зорилго, төлөвлөгөөт зорилтыг ханган биелүүлэхэд ажил үүргийг мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэх чадавхтай хүний нөөцийг бүрдүүлэх, тэднийг сургах, хөгжүүлэх, идэвхжүүлэх, хүний нөөцийн мэдээллийн систем, техник технологийн өөрчлөлт, хөгжлийг нэвтрүүлэх замаар хүний нөөцийн удирдлагын үйл ажиллагааг сайжруулахад хөтөлбөрийн зорилго оршино.

1.2 Хөтөлбөрийн эрх зүйн орчин

Хүний нөөцийн хөтөлбөрийг компанийн 2016-2024 оны 07 дугаар сарын 01-ний ажиллах хүчний судалгаа, тэдний талаар авч хэрэгжүүлсэн нийгэм хангамжийн асуудал,

сургалтанд хамрагдсан ажилтнуудын судалгааг дараах хууль тогтоомж, дүрэм журмын хүрээнд боловсрууллаа. Үүнд:

1. Үндсэн хууль
2. Иргэний тухай хууль
3. Хөдөлмөрийн тухай хууль
4. Эрчим хүчний тухай хууль
5. Компанийн тухай хууль
6. ХАБЭА-н тухай хууль
7. Нийтийн албанд болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль
8. Авлигын эсрэг тухай хууль
9. Компанийн дүрэм
10. Компанийн “Хөдөлмөрийн дотоод журам”
11. Бусад холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам

1.3 Хөтөлбөрийн хэрэгцээ, хамрах хүрээ, хэрэгжүүлэх хугацаа

Компанийн хүний нөөцийн 2024-2030 хүртэлх хөтөлбөр нь компанид чадварлаг мэргэшсэн боловсон хүчнийг бүрдүүлэх, нийт ажилтнуудыг сургаж бэлтгэх, боловсрол, мэргэшлийг дээшлүүлэх, дадлагажуулах, ажилтнуудын ажлын гүйцэтгэлийг үнэлэх, ажилтныг идэвхижүүлэхтэй холбогдсон шийдвэр гаргах, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулахад хөтөлбөрийн хэрэгцээ үүссэн ба энэхүү хөтөлбөрт тус станцын нийт ажилтнууд хамрагдана.

Хөтөлбөрийг 2024-2030 оны хугацаанд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн болно.

1.4. Хөтөлбөрийн хэрэгжилтийн үе шатанд үнэлгээ хийх

Хөтөлбөрийн дагуу авч хэрэгжүүлсэн ажил, хүрсэн үр дүн, гүйцэтгэлд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээг Амгалан дулааны станц ТӨХК-ийн захиргаа нь тухайн оны 12-р сард багтаан дүгнэнэ.

Хөтөлбөрийн хэрэгжилт, ахиц, дэвшил, үйл ажиллагааны үр дагаврыг үнэлж дүгнэх ажлыг 2 үе шаттайгаар зохион байгуулна. Үүнд:

1 үе шат: Хөтөлбөрийн хэрэгжилтийн эхний үе шатны үнэлгээ хийх эхний шатны үнэлгээг дор дурдсан үр дүнд хүрсэн байх шаардлагатай гэсэн үндсэн үзүүлэлтэнд тулгуурлана.

Хүрсэн байх түвшин:

1. Компанийн хүний нөөцийн хэрэгцээ, шаардлагыг дунд хугацаанд оновчтой тодорхойлсны дагуу хүний нөөцийн төлөвлөлтийг боловсруулан, хэрэгжилтийг ханган ажилладаг мехенизм бий болсон байх
2. Компанийн ажилтнуудыг тогтвор суурьшилтай ажиллуулах, хүний нөөцийн төлөвлөлтийн хүрээнд карьер хөгжлийн бодлогыг хэрэгжүүлж эхэлсэн байх
3. Компанийн ажилтнуудыг бэлтгэх, дадлагажуулах, давтан сургах замаар залгамж халааг бэлтгэх хөтөлбөрийг боловсруулж, төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлж эхэлсэн байх
4. Ажилтнуудын сургалтын таатай орчин бүрдүүлж, хэрэгжилтийг хууль эрх зүйд нийцүүлсэн байх
5. Ажилтнуудын чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх Спорт заал, Урлагийн танхимыг тоног төхөөрөмж, техник хэрэгсэлийн хамт бүрэн бэлтгэсэн байх
6. Ажилтнуудыг тогтвор сууршилтай ажиллуулах зорилгоор тэдний нийгмийн асуудлыг шийдвэрлэх журмыг боловсруулж, баталсан байх

2 үе шат: Хөтөлбөрийн хэрэгжилтийн эцсийн шатны үнэлгээ хийх эцсийн шатны үнэлгээг дор дурдсан үр дүнд хүрсэн байх шаардлагатай гэсэн үндсэн үзүүлэлтэд тулгуурлана.

Хүрсэн байх түвшин:

1. Цалин хөлсний талаарх бодлоготой уялдуулан ажилтнуудыг үр дүнтэй, тогтвортой сууршилтай ажиллах нөхцөл, хөшүүрэг бий болгох зорилгоор цалин хөлсний сүлжлийг нэвтрүүлсэн байх
2. Хүний нөөцийн удирдлага, зохицуулалтын механизм бүрдэн хэрэгжиж, төлөвшсөн байх
3. Хүний нөөцийн удирдлагын орчин үеийн чиг хандлага, систем нэвтэрсэн байх
4. Ажлын байранд сонгон шалгаруулах үйл явц тогтмолжиж, хүний нөөцийн хуваарилалт оновчтой хийгдсэн байх
5. Гүйцэтгэлийн удирдлагын тогтолцоо төлөвшиж компанийн зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны үр ашиг, үр нөлөө сайжирсан байх
6. Удирдах албан тушаалтнуудын манлайллын чадавх, хүний нөөцийн мэдлэг чадвар дээшилсэн байх
7. Хүний нөөцийн бодлого болон хүний нөөцийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудтай хамтын ажиллагааны уялдаа холбоо сайжирсан байх
7. Ажилтнуудыг тогтвор сууршилтай ажиллуулах зорилгоор баталсан нийгмийн асуудлыг шийдвэрлэх журам хэрэгжиж эхэлсэн байх

ХОЁР. ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ

2.1 Компанийн хүний нөөцийн бодлого, хөгжлийн тэргүүлэх чиглэл

Компанийн хүний нөөцийн бодлого

Хүний нөөцийн тогтвортой хөгжлийн бодлогыг оновчтой хэрэгжүүлэх, олон талт, өргөн цар хүрээтэй мэдлэг, ур чадварыг эзэмшсэн мэргэжилтэй боловсон хүчинээр багийг бүрдүүлж, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл, ажлын байран дээр өсөж дэвших боломжоор хангана.

Компанийн хүний нөөцийн хөгжлийн тэргүүлэх чиглэл

Тэргүүлэх чиглэл 1:

Сургалтын үйл ажиллагааг бэхжүүлэх

Тэргүүлэх чиглэл 2:

Ажлын гүйцэтгэлийн удирдлагыг төгөлдөржүүлж, ажилтнуудын тогтвор суурьшилтай ажиллах нөхцлийг бүрдүүлэх

2.2 Хүний нөөцийн хөгжлийн стратегийн зорилго

Дээрх тэргүүлэх 2 чиглэлийн хүрээнд дараах стратегийн зорилгуудыг дэвшүүлж байна.

Стратегийн зорилго:

1. Компанийн хөгжлийн хэтийн төлөвт нийцүүлэн бүтээлч сэтгэлгээ бүхий өрсөлдөх чадвартай мэргэжилтэнг бэлтгэх, дадлагажуулах, давтан сургах замаар чадварлаг хүний нөөц бүрдүүлэх, тэдний мэдлэг, ур чадварыг сайжруулах
2. Ажлын төлөвлөлтийг боловсронгуй болгосноор гүйцэтгэлийг үнэлэх нэгдсэн систем тогтоосноор үйлдвэрлэлийн бүтээмж, чанар дээшлэх
3. Ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх журам хэрэгжсэнээр тэдний тогтвор сууршилтай ажиллах нөхцөл хангагдах

ГУРАВ. АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-ИЙН ХҮНИЙ НӨӨЦИЙГ ХӨГЖҮҮЛЭХ СТРАТЕГИЙН ЗОРИЛТ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ, ХҮРЭХ ҮР ДҮН

Хүний нөөцийн стратегийн зорилгуудыг дараах зорилтуудаар дамжуулан хэрэгжүүлнэ.

3.1 Хүний нөөцийн төлөвлөлт, бүрдүүлэлт, мэргэжлийн залгамж халааг бэлтгэх, тогтвортой ажиллуулах хүрээнд:

Зорилт 1: Гадаад болон дотоод орчинд гарч байгаа эрчимтэй өөрчлөлт, хөгжилтэй уялдуулан хүний нөөцийн хэрэгцээ, шаардлагыг оновчтой тодорхойлох

Үйл ажиллагаа:

- Хүний нөөцийн судалгааг хагас жил тутам тогтмол хийж мэдээлэх

Хүрэх үр дүн:

- Хүний нөөцийн судалгаа, тайлан мэдээ нь тогтмол шинэчлэгдэж хэвшсэн байна.
- Байгууллагын хэмжээнд хэрэгцээтэй ажлын байр тодорхойлогдож, хүний нөөцийн бүртгэл мэдээлэлтэй болсон байна.

Зорилт 2: Мэргэжлийн чадварлаг хүний нөөцийг бүрдүүлэх, ажлын байрны таатай орчинг бүрдүүлэх

Үйл ажиллагаа:

- Орчин үеийн хэрэгцээ шаардлага, стандартад нийцүүлэн тав тухтай аюулгүй ажиллах орчинг бүрдүүлэх
- Компанийн эрхэм зорилго, стратеги зорилтуудад үндэслэн компанийн бүтэц, зохион байгуулалт, ирээдүйд шаардагдах хүний нөөцийн хэрэгцээ шаардлагад тулгуурлан шаардлагатай зардлыг тусгасан компанийн хүний нөөцийн төлөвлөлтийг боловсруулан хэрэгжүүлдэг механизмыг бий болгох
- Компанийн хүний нөөцийн төлөвлөлтөнд үндэслэн ажлын байранд тавигдах шаардлага, сонгон шалгаруулалтын шалгуур үзүүлэлтийг боловсронгуй болгох
- Хүний нөөцийн бүрдүүлэлтийн эх үүсвэрийн нэгдсэн санг бий болгох

Хүрэх үр дүн:

- Хүний нөөцийн төлөвлөлтийн хэрэгжилт 85 хувиас багагүй байх
- Шинээр байгуулсан албан тасалгаа, суурилуулсан тоног төхөөрөмж өмнөх жилээс буураагүй байх
- Компанийн хүний нөөцийг бүрдүүлэхдээ тухайн ажлын байрны шаардлагыг бүрэн хангасан, мэдлэг чадвартай иргэнийг сонгон шалгаруулдаг систем хэвшсэн байх

-
-
- Тогтвор суурьшилтай ажиллаж буй ажилтнуудын хувийн жин тогтмол өссөн байх

Зорилт 3: Карьер хөгжлийн бодлого, залгамж халааг бэлтгэх тогтолцоог нэвтрүүлэх

Үйл ажиллагаа:

- Компанийн хүний нөөцийн бодлого, хэрэгцээ, шаардлагатай уялдуулан карьер хөгжлийн бодлогыг тодорхойлох
- Ажилтнуудыг бэлтгэх, дадлагажуулах, давтан сургах замаар залгамж халааг бэлтгэх хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх
- Албан тушаал дэвших, өөр албан тушаалд шилжин ажиллах үйл ажиллагааг нээлттэй, ил тод болгон шударга өрсөлдөөний замаар карьер хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх
- Ажилтнуудын мэргэжил, боловсролыг үе шаттайгаар дээшлүүлж,
- Мэргэжил, боловсрол, ажлын зэрэгтэй ажилтнуудын хувийн жинг 2025 оны жилийн эцсийн түвшингээс бууруулахгүй байх бодлого баримтлах

Хүрэх үр дүн:

- Компани нь карьер төлөвлөлт хийн, хөгжлийн бодлогыг тодорхойлсон байна.
- Бодлогын хүрээнд залгамж халааг бэлтгэх хөтөлбөр, түүний төлөвлөгөөний хэрэгжилт тодорхойлогдсон байна
- Мэргэжил, боловсрол, ажлын зэрэгтэй ажилтнуудын хувийн жинг 2025 оны жилийн эцсийн түвшингээс бууруулаагүй байна.
- Зөвлөх, мэргэшсэн зэрэгтэй ажилтнуудын эзлэх хувийн жин нэмэгдсэн байна.

3.2. Хүний нөөцийн сургалт, хөгжлийн бодлогыг тасралтгүй, үе шаттай хэрэгжүүлэх хүрээнд

Зорилт 4: Сургалтын чанарыг сайжруулах, шинэ технологиор баяжуулах

Үйл ажиллагаа:

- Хүний нөөцийн сургалтын хэрэгцээг бодитоор үнэлж, ажиллах хүчнийг сургаж, дадлагажуулах, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг жил бүр боловсруулан хэрэгжүүлэх
- Сургалтын төлөвлөгөөнд дараах сургалтуудыг нарийн тусгах шаардлагатай.
Үүнд:
 - ✓ Танилцах сургалт
 - ✓ Анхан шатны сургалт
 - ✓ Давтан сургалт
 - ✓ Дадлагажуулах сургалт
 - ✓ Мэргэшүүлэх сургалт
 - ✓ Боловсролын зэрэг олгох сургалт
- Эдгээр сургалтыг байгууллагын сургалтын хэрэгцээнд тус тус үндэслэсэн байх
- Шинээр мэргэжилтэн бэлтгэх, дадлагажуулах үйл ажиллагааг боловсронгуй болгох
- Сургалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэрийг жил бүрийн төсөвт суулгах, сургалтын байгууллагуудтай хамтран ажиллах замаар бүрдүүлэх
- Сургалтын тоног төхөөрөмж, ном, гарын авлагыг үе шаттайгаар шийдвэрлэх

-
-
- Мэргэжлийн ном, хууль, дүрэм, журмын эмхэтгэлийн бааз бүрдүүлж, цахим хэлбэрт шилжүүлэх
 - Мэргэжлийн их, дээд сургууль, сургалтын төвтэй хамтын ажиллагааг тогтоох, өргөжүүлэх

Хүрэх үр дүн:

- Сургалтын тоног төхөөрөмж, ном, гарын авлагаар хангагдсан байна.
- Шалгалтыг цахим хэлбэрээр авдаг систем нэвтрүүлсэн байна.
- Жил бүрийн сургалтын хөтөлбөр оновчтой төлөвлөгдөж, хэрэгжилт бүрэн хангагдсан байна.
- Байгууллагын тухайн жилийн сургалтын төлөвлөгөөний хэрэгжилт 95 хувиас багагүй байна.
- Мэргэшүүлэх, давтан сургалтанд хамрагдсан ажилтнуудын хувийн жин нэмэгдсэн байна.
- Тухайн жилийн сургалтын төлөвлөгөөний санхүүжилтийн эзлэх хувийн жин өмнөх жилээс буураагүй байна.

3.3. Ажлын гүйцэтгэлийн удирдлага, зохион байгуулалтыг оновчтой болгох хүрээнд

Зорилт 5: Үр дүнд суурилсан гүйцэтгэлийн стандарт үзүүлэлтүүд, түүнийг хэмжих хэмжүүрийг тодорхойлох

Үйл ажиллагаа:

- Ажлын бодит гүйцэтгэл, ил тод байдал, урамшууллыг оновчтой уялдуулах механизмыг хэрэгжүүлэх
- Ажилтнуудын ажлын ачаалал болон ажлын үр дүнг бодитой үнэлэх

Хүрэх үр дүн:

- Ажлын үр дүнд суурилсан гүйцэтгэлийн үнэлгээ нэвтэрсэн байна.
- Тариф мэргэжлийн лавлахад заагдсан ажлыг гүйцэтгүүлсэнээр ажлын ачаалал тэнцвэржиж, үр дүнг бодитоор үнэлдэг болсон байна.

Зорилт 6: Ажилтнуудын өөрөө тасралтгүй хөгжих орчинг бүрдүүлэх, үр бүтээлтэй ажиллах хөшүүргийг бий болгох

Үйл ажиллагаа:

- Мэдлэг боловсролоо дээшлүүлж байгаа ажилтнуудыг дэмжих
- Баг хамт олны бүтээлч хамтын ажиллагааг дэмжих
- Хувь хүний манлайллыг дэмжих

Хүрэх үр дүн:

- Мэдлэг боловсролоо дээшлүүлж байгаа ажилтнуудын тоо нэмэгдсэн байна.
- Ажилтнуудын байгууллагад итгэх итгэл нэмэгдэж, ирээдүйг төлөвлөх, өөрийгөө хөгжүүлэх хүсэл эрмэлзлэлтэй болсон байна.

3.4. Цалин хөлс, шагнал, урамшууллын системийг боловсронгуй болгох хүрээнд:

Зорилт 7: Компанийн хэмжээнд мөрдөгдөж буй цалин хөлс, шагнал, урамшууллын тогтолцоог боловсронгуй болгох

Үйл ажиллагаа:

- Ажлын үр дүн, гүйцэтгэлд тулгуурласан урамшуулал, хариуцлагын нэгдсэн систем боловсруулан мөрдөн ажиллах

Хүрэх үр дүн:

- Ажлын үр дүнг цалин хөлс, шагнал, урамшуулалтай уялдуулж, нийгмийн баталгааны талаар баримтлах бодлого хэрэгжиж эхэлсэн байна.
- Ажилтнуудын орлого, нийгмийн баталгааны түвшин дээшилсэн байна.

Зорилт 8: Ажилтнуудын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг байгууллагын хэмжээнд хэрэгжүүлэх тогтолцоог бүрдүүлэх

Үйл ажиллагаа:

- Ажилтнуудын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг байгууллагын хэмжээнд хэрэгжүүлэх
- Ажилтнуудад үзүүлэх нийгмийн хамгааллын үйлчилгээг чанаржуулах, хүртээмжийг нэмэгдүүлэх

Хүрэх үр дүн:

- Ажилтнуудын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилт 80 хувиас багагүй байна.
- Компаниас ажилтнуудад олгогдож буй нийгмийн баталгааны түвшин бууруугүй байна.

3.5. Хүний нөөцийн мэдээллийн систем, техник технологийн өөрчлөлт, хөгжлийг нэвтрүүлэх хүрээнд:

Зорилт 9: Компанийн хүний нөөцийн мэдээллийн нэгдсэн санг бий болгох, техник технологийн дэвшлийг нэвтрүүлэх

Үйл ажиллагаа:

- Компанийн нийт ажилтан, ахмад настнуудад үзүүлэх үйлчилгээ системийг бий болгох
- Компанийн хүний нөөцийн бүртгэл, мэдээллийн санг цахим хэлбэрт шилжүүлсэн байх

Хүрэх үр дүн:

- Компанийн ажилтан, ахмад настануудад үйлчилгээ үзүүлэх ажлыг тогтолжуулсан байна.
- Компанийн хүний нөөцийн бүртгэл бүрэн цахим системд шилжсэн байна.

3.6. Компанийн хүний нөөцийн удирдлага, хяналтыг сайжруулах хүрээнд

Зорилт 10. Удирдах албан тушаалтны манлайллын чадварыг хөгжүүлэх

Үйл ажиллагаа:

- Компанийн хөгжлийн бодлого, манлайллын удирдлагыг шинэ түвшинд гаргах
- Удирдлагын бүх түвшинд эрх мэдэл, үүрэг, хариуцлагын хуваарилалтыг төгөлдөржүүлэх
- Компанийн үйл ажиллагааг төгөлдөржүүлэхэд ажилтнуудын оролцоог идэвхжүүлэх
- Бүтээлч, эвсэг хамт олныг бүрдүүлэхэд чиглэсэн спорт, соёл хүмүүжлийн үйл ажиллагааг тогтмолжуулах

-
- Хөгжлийн зорилгод чиглэсэн төрөл бүрийн /клуб, холбоо, сүлжээ, иргэний нийгмийн байгууллагын/ үйл ажиллагааг дэмжих
 - Соён гэгээрүүлэх, шинжлэх ухаан технологийн ололтыг сурталчлах, эрдэм мэдлэгийг түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааг дэмжих
 - Хамт олны санал бодлыг судлах, удирдлагын шийдвэрт тусгуулдаг зарчмыг хэрэгжүүлэх

Хүрэх үр дүн:

- Хамт олны дунд зохион байгуулсан спорт, соёл, хүмүүжлийн арга хэмжээний тоо чанар дээшилсэн, ажилтнуудын оролцоо нэмэгдсэн байна.
- Хамт олноос авсан санал асуулгын үр дүнг үйл ажиллагаандаа тусгадаг, хэрэгжүүлдэг болсон байна.

ДӨРӨВ. ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨРИЙН САНХҮҮЖИЛТ, ҮР ДҮН

4.1 Хөтөлбөрийн санхүүжилт

Хөтөлбөрт тусгагдсан зорилтуудыг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг компанийн жил бүрийн төсөвт тусган, холбогдох хууль, дүрэм журмын дагуу зарцуулах ба тухай бүр нь хяналт шинжилгээ хийнэ.

Хөтөлбөрийг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ. Үүнд:

- Тухайн жилийн батлагдсан төсөв
- Олон улсын төсөл, хөтөлбөр
- Бусад

4.2 Хөтөлбөрийн үр дүн

Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрнэ. Үүнд:

- Цалин хөлсний оновчтой сүлжил бий болсоноор ажилтнуудын тогтвортой ажиллах нөхцөл, идэвх зүтгэлтэй ажиллах хөшүүрэг бий болсон байна.
- Сургалтын үйл ажиллагаа өмнөх үеэсээ дээшилсэн байна.
- Хүний нөөцийн удирдлага, зохицуулалтын механизм хэрэгжиж, төлөвшсөн байна.
- Удирдлагын ур чадварын менежмент дээшилсэн байна.
- Ажлын байранд сонгон шалгаруулах үйл явц тогтмолжиж, хүний нөөцийн хуваарилалт оновчтой хийгддэг болсон байна.
- Гүйцэтгэлийн удирдлагын тогтолцоо төлөвшиж, байгууллагын зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны үр ашиг, үр нөлөө сайжирсан байна.
- Удирдах албан тушаалтнуудын манлайллын чадавхи, хүний нөөцийн мэдлэг дээшилсэн байна.
- Хүний нөөцийн бодлогын хэрэгжилт чанаржина.

АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-ИЙН ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨГӨӨ

Амгалан дулааны станц ТӨХК-ийн хүний нөөцийг бүрдүүлэх, сургаж хөгжүүлэх, нийгмийн баталгааг хангах замаар ажлын гүйцэтгэлд суурилсан бүтээлч, чадварлаг, тогтвор суурьшилтай хүний нөөцийг бий болгож компанийн тогтвортой хөгжлийг хангахад чиглэнэ гэсэн зорилготой.

Хүний нөөцийн бодлогын 5 зарчмыг баримтлан жил бүрийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулан ажиллана.

№	Зорилго	Зорилт
1	Шударга ёс, ил тод байдал:	Албан тушаал дэвших, өөр албан тушаалд шилжин ажиллах, аливаа үйл ажиллагааг нээлттэй, ил тод, шударга өрсөлдөөний замаар шийдвэрлэх зарчим баримтлах, албан тушаал дэвшүүлэхэд карьер хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх.
2	Мэргэшсэн тогтвортой байдал	Дадлага туршлагатай, мэргэжилтэй боловсон хүчний тогтвор сууршилыг хангахын тулд цалинг ялгавартай тогтоох, нарийн мэргэжлийн, өндөр зэрэгтэй ажилтнуудын хувийн жинг өмнөх жилийн түвшингээс бууруулахгүй байх.
3	Сурч хөгжих боломж	Ажилтнуудад мэргэжил олгох, давтан сургах, мэдлэгийг дээшлүүлэх сургалтыг компанийн Сургалт хөгжлийн журмын дагуу зохион байгуулах. Энэхүү зорилт хэрэгжснээр ажилтнууд чадваржих, тогтвор сууршил хангагдах нөхцөл бүрдэнэ.
4	Хууль дээдлэх, сахилга батыг бэхжүүлэх	Ажлын байрны сахилга, дэг журмыг хангахад хууль дээдлэх зарчмыг баримтлах, хөдөлмөрийн харилцаанд хөдөлмөрийн хууль, хөдөлмөрийн дотоод журам, ажлын байрны тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээ болон холбогдох хууль, дүрэм журам, зааврыг баримтлах.
5	Технологийн хөгжилд тулгуурлах	Сүүлийн жилүүдэд нэвтрүүлсэн өдөр тутмын шуурхай зөвлөгөөн, сургалтуудыг цахимаар үргэлжүүлэн зохион байгуулах. Мөн аюулгүй ажиллагаа болон мэдлэгийн ээлжит болон ээлжит бус шалгалтыг шалгалтын програмаар авах, шалгалтын материалыг олон жил цахимаар архивлаж ажиллах.

ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ

Хүний нөөцийн бодлогыг 5 жилийн хугацаанд хэрэгжүүлнэ. Энэхүү бодлогод тусгагдсан зорилтуудыг компанийн үйл ажиллагааны бизнес төлөвлөгөө болон бусад төсөл, хөтөлбөр, төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлнэ.

Хүний нөөцийн бодлогын зорилтуудын хэрэгжилтийг зохион байгуулах ерөнхий удирдлагыг Гүйцэтгэх захирал хариуцаж, хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээг дараах байдлаар зохион байгуулж, тайлагнана.

Бодлогын хэрэгжилтийн үнэлэх шалгуур үзүүлэлт:

Шалгуур үзүүлэлт	Суурь үзүүлэлт	Хүрэх үр дүн	
		2028	2030
Ажлын байрны хэрэгцээ, шаардлагад нийцсэн мэдлэг, чадвартай хүний нөөцийг бүрдүүлэх, тогтвор суурьшилтай ажиллуулах			
Инженер, техникийн ажилтнуудын эзлэх хувь	20%	50%	75%
6-аас дээш тогтвор суурьшилтай ажилласан ажилтнуудын эзлэх хувь	20%	30%	50%
Ажилтнуудын мэдлэгийн түвшин /мэдлэгийн ээлжит шалгалтын дүнгээр/	Хангалттай бус	Хангалттай	Хангалттай
Ажилтнуудын ур чадварын түвшин /инженерийн үнэлгээгээр/	-	Сайн	Сайн
Хүний нөөцийн сургалт, хөгжлийг компанийн эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн зохион байгуулах			
Сургалтын тоо	20	20-оос доошгүй	20-оос доошгүй
Инженер, техникийн мэдлэг, ур чадвар эзэмшүүлэх сургалт	18	10-аас доошгүй	10-аас доошгүй
Ажилтнуудын хандлагыг сайжруулах сургалт	2	2-оос доошгүй	2-оос доошгүй
Ажилтнуудыг идэвхижүүлэх арга хэмжээ	0	4	4
Ажлын гүйцэтгэлд тулгуурласан цалин хөлс, урамшууллын тогтолцоог хөгжүүлэх, нийгмийн баталгааг дээшлүүлэх			
Үндсэн цалингийн дундаж /арифметик/	1,300,000	1,500,000	1,700,000
Нийгмийн баталгаа /ажилтнуудын үнэлгээ/	-	Сайн	Сайн
Хөдөлмөрийн харилцааны бодлого, зохицуулалтыг сайжруулах, удирдах ажилтны манлайллыг дэмжих			
Хөдөлмөрийн бодлого, зохицуулалтын өөрчлөлт	Ажил олгогч, ажилтны эрх ашигт нийцсэн эсэхээр хэмжинэ.		
Удирдах ажилтнуудын манлайллын хэв маяг	Судалгааны эерэг өөрчлөлтөөр хэмжинэ.		
Ажилтнуудын хандлагын өөрчлөлт	-	Сайн	Сайн